БАЯНХОНГОР АЙМГИЙН ГАЗРЫН ХАРИЛЦАА, БАРИЛГА,
ХОТ БАЙГУУЛАЛТЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ХАГАС ЖИЛИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

2025 оны 06 сарын 10 Номгон

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
| --- | --- | --- | --- | --- | --- | --- | --- |
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **НЭГ. БОДЛОГЫН БАРИМТ БИЧИГТ ТУСГАГДСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ** | | | | | | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2.<br>Навигацын хиймэл дагуулаас мэдээ хүлээн авах суурин станцыг өргөжүүлэх замаар байрлалын сүлжээний нарийвчлалыг 2 см хүртэл сайжруулж, геодезийн хэмжил зураглалын үйл ажиллагаанд ашиглана.** | | | | | | | |
| 1.1.1.2 | Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг шинэчилж хийсэн байна. | Засгийн газрын 2018 оны 384-р тогтоолоор Улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Ерөнхий төлөвлөгөөний аргачлалд санал өгч ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Зөвлөх үйлчилгээг зарласан одоогоор гүйцэтгэгч шалгараагүй байгаа тул гүйцэтгэгчийг мэдээлэлээр хангаж ажиллах боломжгүй байна. | Үнэлэх боломжгүй |
| 1.1.2.3 | Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах. | Үйл ажиллагаа | **Баянхонгор** | 19 аймгийн ГЗБЕТ /Увс, Завхан, Хөвсгөл, Говьсүмбэр, Булган, Хэнтий, Өмнөговь, Дундговь, Төв, Дархан-Уул, Дорноговь, Баян-Өлгий, Баянхонгор, Орхон, | **Эхний хагас жилд:**<br>Аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хийгдэх ажлуудыг зохион байгуулсан байна. | Аймгийн Газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөний хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 117 ажил арга хэмжээний дагуу тухайн жилийн төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.2.4 | Аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний арга хэмжээнүүд цахим системд бүрэн тусгагдсан эсэхэд дүн шинжилгээ хийх, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд хяналт тавих. | Үйл ажиллагаа | **Баянхонгор** | 21 аймгийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө болон тодотголууд цахим системд бүртгэгдсэн. | **Эхний хагас жилд:**<br><br>Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулагдаагүй аймгууд төлөвлөгөөг боловсруулж батлуулах ажлыг зохион байгуулах.<br><br>Цахим системд бүртгэгдсэн төлөвлөгөөний арга хэмжээ бүрэн орсон эсэхэд хяналт тавих. | Аймгийн газар зохион байгуулалтын Ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулахаар бэлтгэсэн. Төлөвлөгөө боловсруулахтай холбоотой цахим системд бүртгэгдсэн арга хэмжээг нягталж байна. Тухайлбал: Цахим системд атаршсан газрын мэдээллийг давхардуулан оруулсан алдаа гарсан бөгөөд Ерөнхий газрын хариуцсан мэргэжилтэнд мэдэгдэж засуулах талаар мэдэгдсэн. | 90 |
| **1.1.3** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулах** | **Орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөр** | **Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан сумдын тоо** | **198 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө хийгдсэн** | **132 сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө боловсруулсан байна.** | | |
| 1.1.3.1 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулах, тайлагнах. | Үйл ажиллага а | Баянхонгор аймгийн 12 сум | Баянхонгор аймгийн<br><br>12 сум | **Эхний хагас жилд:**<br><br>Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний дагуу хэрэгжих ажлуудыг зохион байгуулж ажилласан байна. | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөний хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг сумдаас авч өмнө онуудад хэрэгжээгүй шалтгаануудыг тодорхойлсон. Энэ нь бодит бус төлөвлөсөн, арга хэмжээний төрөл цөөхөн, Систeмд орсон төлөвлөлтүүд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдаагүй, газар олголт хийсэн газруудад бүсүүдийг зөрүүтэй төлөвлөсөн гэх мэт шалтгаануудаас хэрэгжилт хангалтгүй байна. Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажлыг эрчимжүүлэх талаарх албан бичгийг сумдад Газрын даргын 2025 оны 124 дугээр албан бичгээр чиглэл хүргүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.1.3.2 | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллага а | Баянхонгор аймгийн 5 сум | Баянхонгор аймгийн 5 сум | **Эхний хагас жилд:** Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх, тодотгоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулах талаарх саналаа төсвийн тооцоолол болон танилцуулгын хамт сумын ИТХ, Засаг даргад хүргүүлсэн байна. | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөөг шинэчлэх, тодотгох шаардлагатай 5 сумын удирлагуудад төлөвлөгөөг хийхэд шаардагдах төсөв хөрөнгийн талаарх мэдээллийг хийсэн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.2. Бүсчилсэн хөгжлийг дэмжиж, төвлөрлийг сааруулах Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн оновчтой хуваарийг тогтоох** | | | | | | | |
| **1.2.1** | **Хот байгуулалтын тухай, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай, Газрын тухай хууль, тогтоомж холбогдох норм, дүрэмд нийцүүлэн хотын эдэлбэр газрыг тогтоох ажлыг зохион байгуулах** | **Улсын төсөв** | **Эдэлбэр газрыг тогтоосон хот, тосгон бусад суурин газрын тоо** | **Нийслэл Улаанбаатар хотын эдэлбэр газрыг тогтоосон** | **21 аймаг, 330 сум, 12 хилийн боомтын эдэлбэр газрыг тогтоосон байна.** | | |
| 1.2.1.2 | Хотын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинээр боловсруулах, тодотгох талаар аймаг, орон нутгийн удирдлагуудыг мэдээ, танилцуулгаар хангаж | Үйл ажиллага а | Баянхонгор аймгийн 17 сум | Аймгийн хэмжээнд 3 сумын төвийн хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулагд сан | **Эхний хагас жилд:** Хотын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөг боловсруулах, тодотгоход шаардагдах зардлыг орон нутгийн төсөвт тусгуулах талаарх саналаа төсвийн тооцоолол | Сумын нутаг дэвсгэрийн хөгжлийн төлөвлөгөө 13 сумд хийгдсэн бөгөөд 12 сумын төлөвлөгөө цахим системд бүрэн орсон. Баянлиг сум цахим систем нэвтрээгүй үед батлагдсан тул системд орох боломжгүй. Эхний хагас жилийн байдлаар Хүрээмарал, Жаргалант, Бууцагаан, Бөмбөгөр, Заг, Баян-өндөр, Баянговь, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөний зардлыг төсөвт суулгах ажлыг аймгийн Ерөнхий архитектортой хамтран зохион байгуулах | | | | болон танилцуулгын хамт сумын ИТХ, Засаг даргад хүргүүлсэн байна. | Баян-Овоо, Гурванбулаг зэрэг 12 сумын ерөнхий төлөвлөгөө хийлгэхээр аймгийн ОНХСангаас 500 сая, сумдын ОНХСангаас 1550 сая төгрөг шийдвэрлэсэн бөгөөд тендер сонгон шалгаруулалт зохион байгуулж, гүйцэтгэгч компаниудтай гэрээ байгуулсан. Мөн Баянцагаан, Шинэжинст сумдууд 600 сая төгрөгийг ОНХСангаас шийдвэрлэсэн бөгөөд Баянцагаан сум бөгөөд тендер сонгон шалгаруулалт зохион байгуулж, гүйцэтгэгч компанитай гэрээ байгуулсан, Шинэжинст сум худалдан авах ажиллагааг 2025 оны 05 сарын 28 өдөр ахин зохион байгуулж, тендер зарласан. | |
| 1.2.1.3 | “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д батлагдсан болон боловсруулж байгаа Хот байгуулалтын баримт бичгийг бүртгэх ажлыг аймгийн Ерөнхий архитектортой хамтран зохион байгуулах | Үйл ажиллагаа | 17 сум | Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд 2 хөгжлийн ерөнхий төлөвлөгөө бүртгэгдсэн | **Эхний хагас жилд:**<br>-Батлагдсан болон боловсруулж байгаа хотын хөгжлийн болон хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний орон зайн мэдээлэл, тоон өгөгдлийг “Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим систем”-д оруулах | Өлзийт сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөнд 2025 оны Аймгийн иргэдийн төлөөлөгчдийн хурлаар орон сууцны бүсийн хилийн талбайг өөрчлөх, үйлдвэрийг бүсийг гэр хорооллын газар болгон өөрчлөхөөр хэлэлцүүлсэн бөгөөд АИТХурлын 2025 оны 04 дүгээр сарын 02 өдрийн 6/20 дугаар тогтоолоор батлагдсан. Тус өөрчлөлтийг хот төлөвлөлтийн цахим системд бүртгэн оруулах тухай Барилга хот байгуулалтын хэлтсийн даргын 2025 оны 05 дугаар сарын 30 өдрийн 307 тоот албан бичгээр Сонголт дизайн ХХК-д хүргүүлсэн. | 100 |
| **1.2.2** | **Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийг геодезийн солбицлоор тогтоон, баталгаажуулах ажлыг үе шаттай зохион байгуулах** | **Улсын төсөв** | **21 аймаг, 330 сум, Нийслэл, 9 дүүрэг** | **Улсын хэмжээнд хилийн цэсийн 13444 эргэлтийн цэгийн солбицлыг тогтоосон** | **Хилийн цэсийн эргэлтийн цэгүүдийн солбицлыг засаг захиргааны нэгж тус бүрээр боловсруулж ЗГХЭГ-т хүргүүлсэн байна.** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.2.2.1 | Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийн байгалийн хил зааг, хүний гараар бүтээгдсэн объектоор тогтоосон хэсгийн судалгаа хийх | Үйл ажиллага а | 21 аймаг | Улсын хэмжээнд хилийн цэсийн 13444 эргэлтийн цэгийн солбицлыг тогтоосон | **Эхний хагас жилд:** Байгалийн хил зааг, хүний гараар бүтээгдсэн объектоор тогтоосон хилийн цэсийн судалгаа гаргах. | Байгалийн хил зааг, хүний гараар бүтээгдсэн объектоор тогтоосон хилийн цэсийн судалгаа авахаар сумдад Газрын даргын 2025 оны 177 дугаар албан бичгийг хүргүүлсэн. Сумдаас ирсэн судалгаа нэгтгэж ГЗБГЗЗЕГазарт 2025 оны 224 дүгээр албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 1.2.2.4 | Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэс, заагийн цахим системд багийн хилийн заагийг тогтоосон ИТХ-ын тогтоол, хилийн цэсийн маргааны талаарх холбогдох архивын баримт материалыг бүртгэх ажлыг орон нутагтаа зохион байгуулах | Үйл ажиллага а | 21 аймаг | Цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:** Цахим системд урьд онуудад үүссэн хилийн цэсийн маргааний талаарх статистик тоон мэдээ, маргаан шийдвэрлэсэн тухай холбогдох баримт материалыг хилийн цэсийн эргэлтийн цэг бүрээр нөхөн бүртгэх, багийн хилийн зааг тогтоосон аймаг, сумын ИТХ-ын тогтоолыг баг тус бүрээр оруулж цахим архив үүссэх. | Газар зохион байгуулалт, геодези зурагзүйн Ерөнхий газраас 2025 оны 3 дугаар сарын 14 нд хилийн цэсийн мэдээллийн системийн сургалтыг зохион байгуулсан. Дээрх сургалтад хамрагдаж хилийн цэсийн мэдээллийн санд мэдээлэл хэрхэн оруулах заавар авсан. Зааврийн дагуу https://khil.gazar.gov.mn/ хилийн цэсийн мэдээллийн санд 2023 онд бүртгэгдсэн Бөмбөгөр, Галуут болон Хүрээмарал, Заг сумдын хилийн цэсийн бодит маргааныг 2024 онд бүртгэгдсэн Баацагаан, Баян-Овоо сумдын Бэлчээрийн усан хангамжийн бодит бус маргааныг тус тус бүртгэсэн. | 100 |
| 1.2.2.5 | Аймгийн төвтэй ойр сумдын судалгааг гаргаж засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох хэрэгцээ шаардлагыг тодорхойлж, хилийн цэсийг тэлэх саналыг аймаг, сумын ИТХ-аар хэлэлжүүлж | Үйл ажиллага а | 21 аймаг | Монгол Улсын бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлал батлагдсан | **Эхний хагас жилд:** Баруун бүс, Хангайн бүсийн аймгууд аймгийн төвтэй ойр сумдын судалгааг гаргаж, засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хилийн цэсийг тодотгох шаардлагатай эсэх тандан судалгааг хийж, хилийн цэсийг тэлэх саналыг аймаг, сумын ИТХ-аар хэлэлцүүлж | Баянхонгор сум нь тэлэх шаардлага гарсан тул бусад сумруу тэлэх ажлыг зохион байгуулах ажлыг хэсгийг байгуулж өгөх талаарх 2025 оны 1/138 дугаар албан бичгийг аймгийн Засаг даргад хүргүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ГЗБГЗЗЕТ-т ирүүлэх. | | | | ГЗБГЗЗЕГ-т ирүүлсэн байна. | | |
| **1.4.4** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах** | **Үйл ажиллагаа** | **48 станц** | **2013-2024 онд Улсын төсвөөр 43, нийслэлийн төсвөөр УБ хотод 5 станц суурилуулсан.**<br><br>**2024 онд GNSS-ийн байнгын ажиллагаатай 48 станцын нэгдсэн удирдлагын тоглолцоо бүрдүүлсэн.** | **GNSS-ийн байнгын ажиллагаатай 48 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулна.** | | |
| 1.4.4.1 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хэвийн үйл ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Байнгын ажиллагаатай Баянхонгор, Баян-Өндөр 2 станц | 2 станц | **Эхний хагас жилд:** GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцын тасралтгүй хэвийн ажиллагааг хангах ажлыг зохион байгуулсан байна. | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин BHO1, BHO2 станцуудын хэвийн ажиллагааг хангаж ажиллаж байна. Одоогийн байдлаар доголдол, гэмтэл гараагүй хэвийн ажиллаж байна. | 100 |
| 1.4.4.2 | GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын хяналтын хэмжилт нэгтгэх. | Үйл ажиллагаа | Бодит агшны хяналтын хэмжилт - 2 станц | Баянхонгор, БаянӨндөр сумд геодезийн тулгуур сүлжээний цэг, тэмдэгтийг суурилуулсан. | **Бүтэн жилээр:** GNSS-ийн байнгын ажиллагаатай 2 станцын аймгийн төв, нийслэлд суурилуулсан станцын бодит агшны нарийвчлалыг улиралд 1 удаагийн шалгалтын хэмжилт, сум суурин газрын станцуудад хагас жилд 1 удаагийн | Аймгийн төвийн GNSS-ийн байнгын ажиллагаатай суурин станцын бодит агшны хэмжилтийг хийж 192.168.20.24 серверт байршуулсан. 1-р улирлын хэмжилтийг 3 сарын 24-ний өдөр, 2 дугаар улирлын хэмжилтийг 05 сарын 03-ны өдөр байршуулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шалгалтын хэмжилт хийнэ. | | |
| **1.4.6** | **Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх, Геодезийн цэг тэмдэгтийн мэдээллийн санг хөтлөх.**<br><br>**Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээнд нийт 22000 орчим цэг тэмдэгт** | **Геодезийн цэг, тэмдэгтийн мэдээллийн санг шинэчилж, 2022 онд мэдээллийн санг цахимаар түгээх тогтолцоог бүрдүүлсэн.** | **Геодезийн байрлал, өндөр, гравиметр, GNSS-ийн сүлжээний ITRF2008 солбицлын тогтолцоонд тодорхойлсон цэг тэмдэгтийг ITRF2020 солбицлын тогтолцоонд шилжүүлэх ажлыг зохион байгуулна.**<br><br>**Бусад байгууллагын захиалгаар хийгдсэн геодезийн ажлын цэг, тэмдэгтийн мэдээллээр геодезийн цахим сангийн шинэчлэлтийг хөтөлнө.**<br><br>**Геодезийн цэг тэмдэгтийн цахим системийн шинэчлэлтэд хяналт тавьж, 21 аймгаас ирүүлсэн хүсэлтийг баталгаажуулна.** | | |
| 1.4.6.2 | Геодезийн байнгын цэг, тэмдэгтийг хадгалах, хамгаалах, тооллого хийх, нөхөн сэргээх ажлыг зохион байгуула | Үйл ажиллагаа | Нөхөн сэргээсэн цэгийн тоогоор<br><br>(- GNSS-ийн дэд болон | 2019 онд Газрын даргын А/291 дугаар тушаалаар “Геодезийн байнгын цэг | **Эхний хагас жилд**: Нөхөн сэргээсэн цэг тэмдэгтийн хүсэлт ирүүлсэн тухай бүрд хүлээн авч, цахим санд оруулна | Баянхонгор сумын нутаг дэвсгэр дээрх устсан 1цэгийг буруутай этгээдээр нөхөн төлүүлж, 2025 оны АД/2025-45 дугаартай ажлын даалгаврын дагуу ДЦ-3183 дугаартай цэг тэмдэгийг нөхөн сэргээж, байршлыг шилжүүллээ. Уг ажлыг | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | зураглалын сүлжээний цэг, тэмдэгт<br><br>- Өндөр болон гравиметрийн сүлжээний репер, цэг) | тэмдэгтийг хадгалах, хамгаалах, нүүлгэн шилжүүлэх" журмыг баталсан. | | "ГЕОСУРВЭЙ" ХХКомпанитай гэрээ байгуулан гүйцэтгэж хүлээлгэн өглөө. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.7. Газрын нэгдмэл санг эрхлэх, газрын нэгдмэл сангийн цахим системийг хөгжүүлэх** | | | | | | | |
| 1.7.1 | **Монгол Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг зохион байгуулж, газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнийг бүртгэх, хянах, тайлагнах** | **Үйл ажиллага а** | **Газрын нэгдмэл сангийн тооллого, бүртгэл хийх эрх зүйн орчин бүрдэж, өөрчлөлт, шилжилтэд хяналт тавих, тайлагнах боломж бүрдсэн байна.** | **Улсын хэмжээнд газрын нэгдмэл сангийн ангилал, шилжилт хөдөлгөөний тайланг гаргасан.** | **Газрын нэгдмэл санд гарч буй өөрчлөлт, шилжилт хөдөлгөөнд хяналт тавих, тайлагнах боломж бүрдсэн байна.** | | |
| 1.7.1.1 | Байгаль орчны төлөв байдлын БОХ-1.1, БОХ-1.2 тайланг гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | 2024 оны БОХ-1.1, БОХ-1.2 тайлан | Газрын нэгдмэл сангийн 2023 оны улсын нэгдсэн тайлан Засгийн газарт танилцуулагдсан. | **Эхний хагас жилд:** 2024 оны БОХ-1.1, БОХ 1.2 тайланг гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2024 оны БОХ-1.1, БОХ 1.2 тайланг гаргаж ГЗБГЗЗЕГ-т хугацаанд нь хүргүүлсэн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.8. Хот байгуулалтын кадастрын цахим системийг хөгжүүлэх, хэрэглээнд нэвтрүүлэх** | | | | | | | |
| **1.8.1** | **Хот байгуулалтын кадастрын цахим системд өгөгдөл, мэдээлэл бүртгэх** | **Үйл ажиллага а** | **Өгөгдөл мэдээлэл** | **2023 онд программ хөгжүүлэх ажил хийгдсэн.** | **21 аймгийн 330 сумын барилга байгууламж, ИШС, тохижилт ногоон байгууламжийн өгөгдөл мэдээлэл хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэгдсэн байна.** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.8.1.1 | Улсын болон орон нутгийн төсөв, төсөл хөтөлбөрөөр хэрэгжих инженерийн дэд бүтэц, инженерийн бэлтгэл арга хэмжээний зураг төсөл, төлөвлөлтийн давхаргын мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Төлөвлөлтийн 8 давхарга | 2023 онд программ хөгжүүлэх ажил хийгдсэн. | **Эхний хагас жилд:** Төлөвлөлтийн давхаргуудын мэдээллийг бүртгэсэн байна | Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар шинээр хэрэгжиж эхлэсэн дараах ажлуудын давхаргуудыг цахим системд бүртгэн ажил эхлүүлэх зөвшөөрлийг олгосон. Үүнд:<br>1. Баянхонгор аймгийн Өлзийт сумын төвийн инженерийн шугам сүлжээний 2 дугаар ээлжийн ажлын давхаргын мэдээллийг Хот байгуулалтын цахим системд бүртгэн БАЭҮЗ-64-0008/25 дугаар ажил эхлэх зөвшөөрлийн гэрчилгээг олгосон.<br>Баацагаан, Баянцагаан, Баянговь, Баян-Овоо сумдын сургууль, цэцэрлэг, дотуур байрны нүхэн жорлонг стандартын шаардлагад нийцсэн ариун цэврийн байгууламжаар солих ажлыг цахим системд бүртгэн БҮАЭҮЗ-64-0006/25 дугаар ажил эхлэх зөвшөөрлийн гэрчилгээг олгосон. | 100 |
| 1.8.1.2 | Инженерийн шугам сүлжээний хамгаалалт, хориглолтын бүсийг хот байгуулалтын кадастрын мэдээллийн санд бүртгэн оруулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Хамгаалалт, хориглолтын бүс 7 давхарга | 2023 онд программ хөгжүүлэх ажил хийгдсэн. | **Эхний хагас жилд:** Инженерийн шугам сүлжээний хамгаалалт, хориглолтын бүсийн мэдээллийг бүртгэсэн байна. | Жаргалант, Баянхонгор, Баянцагаан, Бууцагаан, Бөмбөгөр, Эрдэнэцогт, Шинэжинст, Баянбулаг, Өлзийт, Заг, Баян-Овоо, Баацагаан, Богд, Жинст, Гурванбулаг, Баянлиг, Баянговь, Баян-Өндөр, Галуут, Хүрээмарал сумдын инженерийн шугам сүлжээний “хамгаалалтын бүс, зурвас газар”-ын мэдээлэл нь Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системд бүртгэгдсэн бөгөөд цахим хөтлөлт тогтмол хийгдэж байна. | 100 |
| 1.8.1.3 | Тэг тэнхлэг улаан шугам, барилга, инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийг хот байгуулалтын кадастрын цахим | Үйл ажиллагаа | Тэг тэнхлэг, байрзүйн гүйцэтгэлийн зураг 2 давхарга | 2023 онд программ хөгжүүлэх ажил хийгдсэн. | **Эхний хагас жилд:** Тэг тэнхлэг улаан шугам болон инженерийн шугам сүлжээний гүйцэтгэлийн зургийн | Тайлант оны эхний хагас жилд www.urban.gov.mn цахим системээр Тэг тэнхлэгийн акт бүртгэх 9 хүсэлт хүлээн авч, 8 буцааж, 1 хүсэлт бүртгэсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | системд бүртгэн оруулах ажлыг зохион байгуулах. | | | | мэдээллийг бүртгэсэн байна. | Гүйцэтгэлийн байрзүйн зургийг мэдээллийн санд бүртгэх 57 хүсэлт хүлээн авсанаас 36 хүсэлтийг буцаасан, 16 хүсэлтийг бүртгэсэн бөгөөд 5 хүсэлт судлагдаж байна. | |
| 1.8.1.4 | Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний өгөгдөл мэдээллийг хот байгуулалтын кадастрын цахим системд бүртгэх ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | 45 давхаргын мэдээлэл | 2023 онд программ хөгжүүлэх ажил хийгдсэн. | Барилга байгууламж, тохижилт, ногоон байгууламж, инженерийн бэлтгэл арга хэмжээ, инженерийн шугам сүлжээ, авто замын сүлжээний 45 давхаргын өгөгдөл мэдээлэл бүртгэгдсэн байна | Эхний хагас жилийн байдлаар шинээр ашиглалтад орсон 17 барилга, цэвэр усны шугам сүлжээ 2, ЦДАШ-1 нийт 20 барилга, байгууламж бүртгэн оруулсан. Мэдээллийн сангийн өмнөх мэдээллүүдийг шинэчилж, бүрэн оруулах төлөвлөгөө гарган ажилласан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.9. Газрын биржийн үйл ажиллагааг боловсронгуй болгож, үйл ажиллагааг өргөжүүлэх** | | | | | | | |
| **1.9.1** | **Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг бий болгоно.** | **Үйл ажиллагаа** | **Цахим үйл ажиллагаатай Газрын бирж** | **Газрын биржийн цахим систем /www.mle.mn/-ийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.** | **Цахим үйл ажиллагаатай газрын биржийг Газрын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагын эрхлэх асуудлын хүрээнд байгуулж, газар, үл хөдлөх хөрөнгө /ҮХХ/-ийн нэгдсэн системийг хэрэглээнд нэвтрүүлсэн байна.** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9.1.2 | Газрын биржийн цахим системээр газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн дуудлага худалдаа, эзэмших, ашиглах эрхийн төсөл сонгон шалгаруулалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | Тухайн жилийн төлөвлөгөөнд тусгагдсан нэгж талбарын тоо | Газрын биржийн цахим системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | **Жилийн турш:** Тухайн жилийн төлөвлөгөөнд дуудлага худалдаа, төсөл сонгон шалгаруулалтаар олгохоор төлөвлөсөн газарт зохион байгуулсан байна. | Аймгийн хэмжээнд 2025 онд 13 сумд 39 нэгж талбарын 374.8926 га газар дуудлага худалдаагаар, 5 сумд 15 нэгж талбарын 25.4683 га газар төсөл сонгон шалгаруулалт зарлагдахаас эхний хагас жилийн байдлаар 6 сумын 19 нэгж талбарт дуудлага худалдаа зарласан. Баянцагаан сумд 2 нэгж талбар, Баян-өндөр сумд 5 нэгж талбарт дуудлага худалдаа зарласан боловч оролцогчгүйн улмаас хүчингүй болж дахин зарлагдахаар төлөвлөж байна. Бөмбөгөр сумд 2 нэгжт талбар, Богд сумд 3 нэгж талбар, Баян-Овоо сумд 3 нэгж талбарт, Баянлиг сумуудад 4, нийт 12 нэгж талбарт дуудлага худалдаа зохион байгуулагдахаар mle.mn цахим сайтад байршуулсан. | 100 |
| 1.10.1.4 | Газрын төлбөр, татварын цахим системээр нийт нэгж талбарт төлбөр бодох, ногдуулалт хийж, нэхэмжлэх үүсгэх, газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Нийт хүчинтэй гэрээний тоо | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Хуульд заасан хугацаанд Татварын нэгдсэн системд бүх ногдуулалтыг илгээсэн байна. | Аймаг хэмжээнд 859 000 000 төгрөгийн газрын төлбөр төвлөрүүлэхээр төлөвлөгдснөөс тайлант оны эхний хагас жилд 25722 нэгж талбарт 713 068 000 төгрөгийн нэхэмжлэлийг үүсгэж татварын удирдлагын нэгдсэн системд илгээж, уг системээс газрын төлбөр, татварын төлөлтийн мэдээллийг хүлээх авах ажлыг зохион байгуулан ажиллаа. Ногдуулалт үүсээгүй шалгаан нь: газар эзэмшигч, өмчлөгч иргэн нас барсан, татвар төлөгчөөр бүртгүүлээгүй, гэрээний хугацаа дууссан гэх мэт шалтгаантай байна. | 90 |
| 1.11.1.1 | Газрын үнэлгээний цахим системийн газрын нөхөх олговрын мэдээллийн санг бүрдүүлэх, нөхөх олговртойгоор газар чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын нөхөн бүрдүүлэлт хийх, | Үйл ажиллагаа | Систем хөгжүүлсэн байдал | Газрын үнэлгээний цахим систем хэрэглээнд нэвтэрсэн | **Эхний хагас жилд:** Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газрын мэдээллийн санг бүрдүүлэх. | Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор газар чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газар эхний хагас жилд бүртгэгдээгүй. Түр барилга байгууламжийг буулгах ажилд 300.0 сая төгрөгийг 2025 оны төсөвт тусган батлуулсан бөгөөд энэ онд 22 граж, 5 амбаар чөлөөлөх гэрээ байгуулан ажилласан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | мэдээллийн сан хөтлөх | | | | | | |
| 1.11.1.3 | Үл хөдлөх эд хөрөнгө зуучлагч байгууллагаас газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээлэл, Газар, үл хөдлөх хөрөнгийн барьцааны болон нөхөн олговрын үнийн мэдээлэл, зах зээлийн санал болгосон буюу зарлан мэдээлсэн үнийн мэдээллийг тус тус цуглуулах | Үйл ажиллагаа | эрх шилжсэн тоо | Кадастрын мэдээллийн нэгдсэн системээр зохион байгуулах боломж бүрдсэн. | **Эхний хагас жилд:** Газрын биржийн цахим системд эрх шилжсэн газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна. | Газрын биржийн цахим системд эрх шилжсэн 70 газар, Худалдах худалдан авах гэрээний үндсэн дээр газар өмчлөх эрхээ шилжүүлсэн 143 газар, нийт 213 нэгж талбарын үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг цуглуулж, дүн шинжилгээ хийсэн байна. | 100 |
| 1.11.1.4 | Зах зээлийн үнийн мэдээг газрын үнэлгээний системд оруулж дүн шинжилгээ хийх, масс үнэлгээ тооцох | Үйл ажиллагаа | эрх шилжсэн тоо | Газрын үнэлгээний системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн газар, үл хөдлөх хөрөнгийн үнийн мэдээллийг үнэлгээний цахим системд оруулж дүн шинжилгээ хийсэн байна. | Аймгийн хэмжээнд Газрын биржийн цахим системд бүртгэгдсэн 213 нэгж талбарын зах зээлийн үнийн мэдээллийг газрын үнэлгээний системд оруулж утгыг бодуулж масс үнэлгээ хийсэн. Газрын үнэлгээний цахим системд Газрын биржийн цахим систем /MLE.MN/ болон газрын кадастрын мэдээллийн системд гарсан өөрчлөлтийг тухай бүр бүртгэн оруулж масс утгыг бодуулсан. | 100 |
| 1.11.1.5 | Иргэн, хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт | Үйл ажиллагаа | Газрын зах зээлийн үнийн мэдээллийн тоо | Газрын үнэлгээний систем | **Эхний хагас жилд:** Иргэн хуулийн этгээдэд олгогдсон газарт дуудлага худалдааны анхны үнэ төлсөн болон нөхөх олговроор олгосон, чөлөөлсөн талаарх өгөгдөл мэдээллийг цуглуулан боловсруулалт хийж, мэдээлтийн сан үүсгэж | Газрын кадастрийн мэдээллийн сангийн нэмэлт өөрчлөлтөөр дуудлага худалдааны анхны үнэ төлсөн мэдээллийн цэс гэрээнд нэмэгдсэн. Үүнтэй холбоотойгоор аймгийн хэмжээнд иргэн, хуулийн этгээдэд олгогдсон нийт газарт бодуулахаас эхний хагас жилд 2689 нэгж талбар бодуулсан. Газрын үнэлгээний цахим системд нөхөх олговортойгоор газар чөлөөлсөн, солих буюу эргүүлэн авсан газар эхний хагас жилд бүртгэгдээгүй. Түр барилга байгууламжийг | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хийж, мэдээллийн сан үүсгэх | | | | ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | буулгах ажилд 300.0 сая төгрөгийг 2025 оны төсөвт тусган батлуулсан бөгөөд энэ онд 22 граж, 5 амбаар чөлөөлөх гэрээ байгуулан ажилласан. | |
| 1.11.1.6 | Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн нэгж талбарт газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэх | Үйл ажиллагаа | Тусгай зөвшөөрөл олгосон тоогоор | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Энхий хагас жилд:** Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр газар ашиглах эрхийг баталгаажуулан мэдээллийн санд бүртгэсэн газрын төлбөр тооцож, ногдуулалт үүсгэсэн байна. | Ашигт малтмал, газрын тосны газраас ашиглалтын тусгай зөвшөөрөл олгосон талбайн хэмжээгээр Газрын кадастрын цахим системд 8 сумын 62 нэгж талбарын 34171.3755 га газар бүртгэгдэж газрын төлбөрийн ногдуулалтыг үүсгэн мэдээллийн санг эрхэлсэн. | 100 |
| 1.11.1.7 | Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөлт хийх бүх боломжуудын талаар иргэд, олон нийтэд сурталчлах | Үйл ажиллагаа | Олон нийтэд сурталчилсан ажлын тоо | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Жилийн турш:**<br><br>Газрын төлбөр, татвар, тэмдэгтийн хураамж, үйлчилгээний хураамжийг цахимаар төлөх боломжуудыг иргэд олон нийтэд сурталчилах ажлыг зохион байгуулсан байна. | Газрын харилцааны цахим фэйж хуудас, emongolia.mn, egazar.gov.mn, банкны аппликэйшн, ebarimt-г дамжуулан газрын төлбөр, татвар, хураамжийг цахимаар хэрхэн төлөлт хийх талаар танилцуулгыг бэлтгэн гарын авлага тарааж сурталчилсан. Мөн 5 сард хангайн 6 сумд нээлттэй хаалганы өдөрлөгөөр иргэдэд мэдээлэл өгч ажиллаа.<br>Газрын биржийн цахим системийн шинэчилсэн хувилбараар 3 сарын 11-нд сумдын газрын даамлуудад танхимын сургалтыг зохион байгуулж, ГЗБГЗЗЕГазраас цахимаар мэдээлэл хийсэн. | 100 |
| 1.11.1.8 | Төлбөрийн даалгавар үүсгэн улсын тэмдэгтийн хураамж, хураамжийн ногдуулалтыг хийж татварын удирдлагын нэгдсэн системд илгээх | Үйл ажиллагаа | Эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор | Газрын төлбөр, татварын системийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Газар эзэмших эрх шилжүүлсэн, барьцаалсан, эзэмших, ашиглах эрх олгосон, хугацаа сунгасан нэгж талбарын тоогоор улсын тэмдэгтийн хураамжийн төлбөрийн | Аймгийн хэмжээнд газар эзэмших эрхийн гэрчилгээ барьцаалах, чөлөөлөх тухай 204 цахим хүсэлт ирснийг хугацаанд нь хүлээн авч шийдвэрлэсэн. Үүнээс шинээр болон нэмэлт барьцааны бүртгэлтэй 138 нэгж талбарт төлбөрийн даалгавар үүсгэн төлүүлсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг зохион байгуулах | | | | даалгавар үүсгэсэн байна. | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.12. Эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж, газрын харилцааны салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангуулах** | | | | | | | |
| **1.12.1** | **Төлөвлөгөөт болон төлөвлөгөөт бус, урьдчилан сэргийлэх, гүйцэтгэлийн хяналт шалгалт хийх** | **Улсын төсөв 185,0 сая төгрөг** | **Хяналт шалгалтад хамруулсан объектын гүйцэтгэлийн хувь,**<br><br>**Илэрсэн зөрчил арилалтын хувь,**<br><br>**Хууль сахин мөрдөлтийн түвшин;** | **2024 онд хяналт шалгалтад хармагдах объектын 90 хувийг хамруулсан.**<br><br>**Илэрсэн зөрчлийн 73.9%-ийг арилгуулсан. Хууль сахин мөрдөлтийн түвшин 78.1% байна.** | **Их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектод хяналт шалгалт хийж, эрсдэлийн түвшин болон хууль сахин мөрдөлтийн хувийг бууруулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулсан байна.** | | |
| 1.12.1.1 | Улсын хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн 15 объектод төлөвлөгөөт хяналт шалгалт хийх, эрсдэлийн түвшин бууруулж, улсын байцаагийн гаргасан шийдвэрийн биелэлтийг хангуулах | Үйл ажиллагаа | Хяналт шалгалтад хамруулсан объектын гүйцэтгэлийн хувь,<br><br>Илэрсэн зөрчил арилалтын хувь,<br><br>Хууль сахин мөрдөлтийн түвшин; | 2024 онд хяналт шалгалтад хармагдах объектын 73 хувийг хамруулсан.<br><br>Илэрсэн зөрчлийн 56%-ийг арилгуулсан.<br><br>Хууль сахин мөрдөлтийн түвшин 68% байна. | **Төлөвлөгөөт хяналт шалгалтад их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектын 95 хувийг бүрэн хамруулсан байна.**<br><br>**Эрсдэлийн түвшин болон хууль сахин мөрдөлтийн хувийг бууруулсан байна. Улсын байцаагчийн гаргасан шийдвэрийн биелэлтийг бүрэн хангуулж, илэрсэн зөрчлийг арилгуулсан байна.** | ГЗБГЗЗЕГ-ын даргын баталсан 35-00/01 дугаар удирдамжийн дагуу төлөвлөгөөнд тусгагдсан 7 объектод төлөвлөгөөт хяналт шалгалтыг хийж гүйцэтгэсэн. 3 объект үйл ажиллагаа явуулаагүй тул шалгалтад хамрагдаагүй. Шалгалтаар 6 объект дунд эрсдэлтэй, 1 объект бага эрсдэлтэй үнэлэгдэж, нийт 48 зөрчил илэрч, 6 объектод 29 заалт бүхий улсын байцаагчийн хугацаатай албан шаардлагаар үүрэг өгсөн. 6 объектод Зөрчлийн тухай хуулийн дагуу 4.5сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээ тооцсон. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.12.1.4 | Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэрээр төлөвлөгөөт бус хяналт шалгалт хийх | Үйл ажиллагаа | Хяналт шалгалт хийсэн объектын зөрчил арилалтын хувь | 2024 онд Иргэн, хуулийн этгээдийн хүсэлт, өргөдөл, гомдол, мэдээлэл, эрх бүхий байгууллагын шийдвэр ирээгүй. | Батлагдсан удирдамжийн хүрээнд хяналт шалгалтыг хийж илэрсэн зөрчлийг арилгуулсан байна<br>Иргэн, хуулийн этгээдээс ирүүлсэн хүсэлт, өргөдөл, гомдлын дагуу төлөвлөгөөт бус шалгалт хийж, дүнг холбогдох хурлаар хэлэлцүүлэн, илэрсэн зөрчлийг бүрэн арилгуулах арга хэмжээг зохион байгуулсан байна. | Баянхонгор аймгийн Засаг даргын 2025 оны А/155 дугаар захирамж, Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын даргын баталсан 35-16/02 дугаар удирдамжийн дагуу “Эрдэнэ Монгол” ХХК, “Сэкер ресорсус монголиа” ХХК, “Наранмандал Энтерпрайзес” ХХК-ийн үйл ажиллагаанд 2025 оны 03 дугаар сарын 26-наас 04 дүгээр сарын 01-ний өдрүүдэд төлөвлөгөөт бус шалгалт хийсэн. Хяналт шалгалтаар илэрсэн зөрчлийг арилгуулахаар “Наранмандал Энтерпрайзес” ХХК, “Эрдэнэ Монгол” ХХК-уудад тус бүр 5 заалт бүхий улсын байцаагчийн хугацаатай албан шаардлага үйлдэж, хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүрэг болгосон. Илэрсэн зөрчил дутагдалд “Наранмандал Энтерпрайзес” ХХК-д Зөрчлийн тухай хуулийн 8.1.10.1 дэх заалтын дагуу 5.0 сая төгрөгний шийтгэлийн арга хэмжээг тооцов.<br>Хүн, хуулийн этгээдээс ирсэн 4 хүсэлтийг хүлээн авч, зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж, 6.5 сая төгрөгийн шийтгэлийн арга хэмжээг авсан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.13. Зайнаас тандан судлалын арга зүйг нэвтрүүлсэн газар ашиглалт, газрын мониторингийн байнгын ажиллагаатай хяналтын системийг хөгжүүлж, газрын мониторингийн цахим системээр дамжуулан үйл ажиллагааг хэвийн тогтвортой эрхлэх, иргэд олон нийтийг мэдээллээр хангах** | | | | | | | |
| **1.13.1** | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлыг бүрэн цахимжуулж, өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон нийт газрын 60 хувьд, төрийн өмчийн бусад ангиллын газрын 50 хувьд газрын төлөв байдал, чанарын | Улсын төсөв, орон нутгийн төсөв, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн өөрийн хөрөнгө | Баталгаажуулсан дүгнэлтийн тоо, хамрагдсан талбайн хэмжээ, га-аар | Газрын монитонгийн цахим системийг 2020 хэрэглээнд нэвтрүүлсэн. 2024 оны байдлаар улсын хэмжээнд 67,000 орчим иргэн, хуулийн этгээд өөрийн өмчлөл, | Газрын төлөв байдал, чанарын захиалгат болон төлөвлөгөөт хянан баталгааны ажлын тайланг нэгтгэж, Засгийн газарт танилцуулсан байна. | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хянан баталгааны дүгнэлт гаргах ажлыг зохион байгуулах | | | эзэмшил, ашиглалтад байгаа газартаа төлөв байдал чанарын захиалгат хянан баталгааны дүгнэлт гаргуулсан. 2018 онд нийслэл, 17 аймгийн тариалан, атаршсан газрын ГТБЧУХБ-ны ажлыг 469,214.8 га талбайд, 2020-2024 онд улсын хэмжээнд 3000 цэгт хийж гүйцэтгэсэн. | | | |
| 1.13.1.1 | Мэргэжлийн байгууллагуудын хийж гүйцэтгэтгэсэн газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын тайлан, дүгнэлтийг хянаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны баталгаажсан тайлан, дүгнэлтийн тоо | ГМЦС-д 2020-2024 онд нийт 66,679 тайлан, дүгнэлт баталгаажсан. | **Эхний хагас жилд:** Цахимаар илгээсэн хянан баталгааны тайлан, дүгнэлтийг хянаж баталгаажуулсан байна.<br><br>Орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын даалгаврыг боловсруулж ГЗБГЗЗЕГ-аас санал авч батлуулах, холбогдох үе | Баянхонгор, Бууцагаан, Баянбулаг, Баянлиг, Шинэжинст, Өлзийт сумдад орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийгдэх газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажлын даалгаврыг боловсруулж ГЗБГЗЗЕГ-аас санал авч батлуулсан. Баянхонгор сумд газрын төлөв байдал, чанарын төлөвлөгөөт хянан баталгааны ажил гүйцэтгэх тендер зарлаж Гранд амур ХХК шалгарсан. Бууцагаан, Баянбулаг, Баянлиг, Шинэжинст, Өлзийт сумууд гүйцэтгэгчийг шалгаруулж гэрээ байгуулсан ба хээрийн судалгааны ажоыг гүйцэтгэсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | шатны ажлын гүйцэтгэлд хяналт тавьж ажилласан байна.<br><br>Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны нэгдсэн тайланг боловсруулж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | | |
| 1.13.1.3 | Орон нутагт газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын гүйцэтгэлд хяналт тавих | Үйл ажиллагаа | Баталгаажсан газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, дүгнэлтийн тоо | ГМЦС-д 2020-2024 онд нийт 66,679 тайлан, дүгнэлт баталгаажсан. | **Эхний хагас жилд:** Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх шаардлагатай нэгж талбарын судалгааг гаргаж, газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагч нарт мэдэгдэх хуудсыг хүргүүлсэн байна. Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлыг зохион байгуулсан байна. | Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газрын даргын 2025 оны 02 дугаар сарын 19-ны 88 дугаар “Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгаа хийлгэх шаардлагатай нэгж талбарын судалгааг гаргаж ирүүлэх тухай” албан бичгийг Сумдын Засаг дарга нарт хүргүүлсэн. Ирүүлсэн судалгааг нэгтгэж 10 нэгж талбарт захиалгат хянан баталгаа хийлгэх мэдэгдэх хуудас хүргүүлсэн. | 100 |
| **1.13.3** | **Газрын төлөв байдал, чанарын хянан баталгаа, газрын мониторингийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийж, илэрсэн газар ашиглалтын зөрчил, хохирол, бохирдлыг** | **Улсын төсөв, 1,370.0 сая** | **Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын үр дүнгээр илэрсэн газар ашиглалтын зөрчил, бохирдол доройтолд өртсөн газрын байршил, талбайн** | **2019 онд 15,000 цэг бүхий Газрын мониторингийн сүлжээг байгуулж, 2020-2024 онд нийт 3000 цэгт газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны судалгаа,** | **Газрын мониторингийн цахим системийн мэдээллийн санд 4000 мониторингийн цэгт судалгаа, шинжилгээ хийж мэдээллийн санг шинэчилж, цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийж, газар ашиглалтын зөрчил, бохирдол доройтолд өртсөн эсэхийг шууд хянан боломжтой** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **арилгах хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх** | | **хэмжээ, хариу авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо** | **шинжилгээ хийсэн.** | **хяналтын тогтолцоог бүрдүүлсэн байна.** | | |
| 1.13.3.2 | Газрын төлөв байдал, чанарын хянан баталгааны ажлын үр дүнгээр илэрсэн газар ашиглалтын зөрчил, хохирол, бохирдлыг арилгах хариу арга хэмжээг төлөвлөж, хэрэгжүүлэх | Үйл ажиллагаа | Хэрэгжүүлсэн арга хэмжээний тоо | ГМЦС-д 2024 онд 11,737 газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, дүгнэлт баталгаажсан. | **Эхний хагас жилд:** Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны ажлын үр дүнгээр газар ашиглалтын зөрчил, хохирол, бохирдолд өртсөн газрын судалгааг гаргаж, хэрэгжүүлэх арга хэмжээний тайланг нэгтгэж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | Газрын мониторингийн цахим системд 2024 онд 52 нэгж талбарын газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны тайлан, дүгнэлт баталгаажсан ба 2025 оны хагас жилийн байдлаар 3 нэгж талбар дээр захиалгат хянан баталгаа хийгдсэн газар ашиглалтын зөрчил, хохирол, бохирдолд өртсөн нэгж талбар илрээгүй байна.<br>Газрын төлөв байдал, чанарын захиалгат хянан баталгааны нэгдсэн тайланг боловсруулж газрын даргын 2025 оны 05 дугаар сарын 14-ны өдрийн 247 тоот албан бичгээр ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.14. Газар хамгаалах, нөхөн сэргээх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, нэгдсэн мэдээллийн сан байгуулах** | | | | | | | |
| **1.14.2** | **Маш хүчтэй болон хүчтэй доройтсон газрын байршил, хэмжээ, шалтгааныг газрын мониторингийн үйл ажиллагааны хүрээнд цуглуулсан мэдээнд дүн шинжилгээ хийж үнэлж, тогтоох, нөхөн сэргээх арга хэмжээг газар зохион байгуулалтын төлөвлөгөөгөөр дамжуулан хэрэгжүүлэх** | **Улсын төсөв, орон нутгийн төсөв, 8,000.0 сая** | **Нийт газар нутгийн хэмжээнд газрын нэгдмэл сангийн ангиллын газарт хохирол учирсан газрын байршил, талбайн хэмжээ** | **2023 онд улсын хэмжээнд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг нийт газар нутгийн 2.49 хувь буюу 3.89 сая га талбайд хэрэгжүүлсэн. /ГНСТ-10 маягт/** | **Хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон газарт нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө үе шаттай бүрэн хэрэгжиж, нөхөн сэргээлт хийгдсэн байна.** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.14.2.1 | 2024 оны Газрын нэгдмэл сангийн тайлангийн Газарт учруулсан хохирлын тайлан (ГНСТ-9 маягт)-аас маш хүчтэй доройтсон газрыг тодорхойлох, нөхөн сэргээх саналыг боловсруулж ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | Үйл ажиллагаа | Нөхөн сэргээх арга хэмжээ авах шаардлагатай газрын талбайн хэмжээ, га | ГЗБГЗЗГ-ын даргын 2020 оны А/136 дугаар тушаалаар 7 аймгийн 26 нэгж талбарын 8,021 га хүчтэй элэгдэл, эвдрэлд орсон тариалангийн талбайд нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө батлагдсан. | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн ангилал тус бүрээс маш хүчтэй доройтолд өртсөн талбай болон нөхөн сэргээх байршлуудыг тодорхойлж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2024 оны Газрын нэгдмэл сангийн тайлангийн Газарт учруулсан хохирлын тайлан (ГНСТ-9 маягт)-аас маш хүчтэй доройтолд өртсөн талбай байхгүй. | 100 |
| 1.14.2.2 | Орон нутагт газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний хэрэгжилтэд хяналт тавих | Үйл ажиллагаа | Нөхөн сэргээхээр төлөвлөж, хэрэгжсэн арга хэмжээний тоо, талбайн хэмжээ, га | 2023 оны Газрын нэгдмэл сангийн нэгдсэн тайлангаар газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээг 3.89 сая га талбайд хэрэгжүүлсэн. | **Эхний хагас жилд:** Орон нутгийн хэмжээнд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ төлөвлөсөн байдал болон шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэсэн талаар судалгаа гаргаж, ГЗБГЗЗЕГ-т хүргүүлсэн байна. | 2025 оны Газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөнд Өлзийт сумд бэлчээр ашиглах хамгаалах нөхөн сэргээх үйл ажиллагаа 683.4 га, Баянбулаг, Заг, Хүрээмарал сумд хортон, мэрэгчтэй тэмцэх бэлчээр 21832.02га Баянбулаг сумд өнжөөж амраах бэлчээр 204808.72га, Баян-Өндөр, Баянцагаан, Бөмбөгөр, Жинст, Богд сумд сэлгэж ашиглах бэлчээр 1235131.4га Бөмбөгөр сумд тордон сайжруулах бэлчээр 3 га, Богд сумд цөлжилт, элсний нүүлтэд өртсөн бэлчээрийн газрыг сэргээн сайжруулах төлөвлөлт 15 га нийт 1462473.54 га талбайд газар хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээ төлөвлөсөн. Төлөвлөгөөний дагуу сумын Засаг даргын шийдвэрийг үндэслэн хамгаалах арга хэмжээг дэс дараатай зохион байгуулж байна. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1.18. Төрийн үйлчилгээний ил тод байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлэх замаар салбарын хэмжээнд цахим шилжилт хийх үйл ажиллагааг дэмжих** | | | | | | | |
| 1.18.1 | **Төрийн үйлчилгээний нэгдсэн системд салбарын** | **Үйл ажиллагаа** | **Цахим төрийн үйлчилгээний тоо** | **Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110** | **Засгийн газрын 2023 оны 100 дугаар тогтоолд заасан 28 үйлчилгээг Төрийн үйлчилгээний** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **үйлчилгээг холбох, байршуулах ажлыг асуудал эрхлэсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран зохион байгуулах** | | | **дугаар тогтоолоор үйл ажиллагаанд нэвтэрсэн Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системээс 42 үйлчилгээг цахим хэлбэр иргэн, хуулийн этгээдэд үзүүлж байна.** | **нэгдсэн системд бүрэн холбох** | | |
| 1.18.1.2 | Тоон гарын үсгийн олголт хийх, өдөр тутмын үйл ажиллагаанд ашиглахад арга зүйн зөвлөгөөгөөр хангах | Үйл ажиллагаа | -Тоон гарын үсэг эзэмшигчийн тоо<br><br>-Тоон гарын үсгийг ашиглаж буй үйл ажиллагааны тоо | Байгууллагын хэмжээнд нийт 1 тоон гарын үсгийг шинэчлэн олгосон. | Эхний хагас жилд: Тоон гарын үсгийн хэрэгцээг тодорхойлон, хэрэглэгчдэд тоон гарын үсгийн олголт хийсэн байна. | Монголын цахилгаан холбоо компаниас Tridumkey тоон гарын үсгийн төхөөрөмжийн хугацаа сунгах, 2 хэлтсийн даргад шинэ албаны тоон гарын үсэг авах хүсэлтийг газрын даргын 03 сарын 17-ний өдрийн 128 албан бичгээр хүргүүлж, албаны тоон гарын үсэг шинээр олгуулсан.<br>Албан бичиг солилцоо тоон гарын үсгээр гарч эхэлсэн. | 100 |
| 1.18.1.3 | Газрын харилцааны бүтээгдэхүүн үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор ухаалаг төхөөрөмж /киоск/-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлэх, хэвийн | Үйл ажиллагаа | Үйл ажиллагаанд шинээр оруулсан ухаалаг төхөөрөмж /киоск/-ийн тоо | Аймгийн хэмжээнд нийт 1 ширхэг ухаалаг төхөөрөмж /киоск/-ийг нэвтрүүлсэн. | Эхний хагас жилд:<br><br>Газрын харилцааны бүтээгдэхүүн үйлчилгээг иргэн хуулийн этгээдэд түргэн шуурхай хүргэх зорилгоор ухаалаг төхөөрөмж /киоск/-ийг үйл ажиллагаандаа нэвтрүүлж, хэвийн үйл | Киоск машиныг аймгийн “Төрийн үйлчилгээний нэгдсэн төв”-д байршуулсан. Үйл ажиллагаа нь цахилгаан тасарсанаас үүдэн 2 удаа, системийн алдаанаас болж 1 удаа доголдсоныг Эрхэт инноваци ХХК-ны мэргэжилтэн Дэлгэрдалайтай "ultra veiwer”-аар холбогдон хэвийн ажиллагаанд оруулсан. Сумдын Иргэдийн хурлын дарга, Засаг дарга нарт Газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэх | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | үйл ажиллагааг хангах | | | | ажиллагааг ханган ажилласан байна. | бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, чанарыг сайжруулах, тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх egazar.gov.mn цахим сайтаар үйлчилгээ авах нөхцөл боломжоор хангах зорилгоор киоск төхөөрөмж худалдан авч үйлчилгээнд нэвтрүүлэхийг зөвлөсөн албан бичгийг 2025.06.02-ны өдрийн 317 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 1. 19. Архивын сан хөмрөгийн баримтыг тогтоосон журам, стандартын дагуу хадгалж, хамгаалах** | | | | | | | |
| **1.19.1** | **Төрийн архивын зориулалтын байр бариулах** | Үйл ажиллагаа | **ТЭЗҮ** | **Байр барих газрын асуудлыг шийдвэрлүүлсэн** | 2789 хадгаламжийн нэгжийн баримтыг цахимжуулан цахим системд холбоно. | | |
| 1.19.1.1 | Архивын албан мэдээллийг бүрдүүлэн, сан хөмрөг үүсгэх, архивлах | Үйл ажиллагаа | Архивт ирүүлсэн ажлуудыг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэх | 2024 онд 206 ажлын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авч, бүртгэл үүсгэсэн. | **Эхний хагас жилд:** . Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэнэ. | Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу албан хаагчдаас байнга хадгалах 64 хадгаламжийн нэгж, түр-10 жил хадгалах 118 хадгаламжийн нэгж, 70 жил хадгалах хадгаламжийн нэгж 92 нийт 274 хадгаламжийн нэгжийг байгууллагын архивт хүлээн авч санд шилжүүлсэн. | 100 |
| 1.19.1.4 | Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авах Хүлээн авсан ажлын жагсаалтыг гаргаж, данс бүртгэл үүсгэх | Үйл ажиллагаа | Архивт ирүүлсэн ажлуудыг хүлээн авч хадгаламжийн нэгж үүсгэх | 2023 онд 2583 ажлын 26820 хуудас баримтын бүрдлийг шалгаж акт үйлдэн хүлээн авч, данс бүртгэл үүсгэсэн. | Эхний хагас жилд: . Байгууллагын хөтлөх хэргийн нэрийн жагсаалтад заасан болон архивт ирүүлсэн ажлыг хүлээн авч, данс бүртгэл үүсгэнэ. | Байгууллагад хөтлөгдөх 2024 оны ХХНЖ-ийн дагуу албан хаагчдаас архивт баримтыг хүлээн авсан. Байнга хадгалах 64, түр-10 жил хадгалахын 118, 70 жилийн 92, нийт 274 хадгаламжийн нэгж хүлээн авч бүртгэл үйлдэж санд шилжүүлсэн. | 100 |
| **1.19.2** | **Төрийн архивын байрны зураг төсөл боловсруулах** | **Үйл ажиллагаа** | **1 танилцуулга** | **-** | **Танилцуулга бэлтгэсэн байна.** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1.9.2.2 | “Архивын улсын үзлэг”-т бэлтгэх, хамрагдах | Үйл ажиллагаа | 1 төлөвлөгөө | 2020 онд “Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг” зохион байгуулагдсан. | Эхний хагас жилд: Төрийн байгууллагын ажлын зохион байгуулалт, архив, албан хэрэг хөтлөлтийн улсын үзлэг”-т бэлтгэх төлөвлөгөө боловсруулан баталж, хэрэгжүүлэх ажил зохион байгуулсан байна. | Архивын улсын үзлэгт бэлтгэн төлөвлөгөө гаргаж ажиллаж байна. Төлөвлөгөөнд тусгасан албан хаагчдын архив, албан хэрэг хөтлөлтийн талаар бүх албан хаагч, сумдын даамлуудад сургалт орсон. Хөтлөх хэргийн нэрийн жагсаалтын дагуу 2024 оны баримтыг байгууллагын архивт хүлээн авч бүртгэл үйлдэж санд шилжүүлсэн. Байгууллагын ХХНЖ-ыг албан хаагчдаас санал авч, шинээр гарсан үлгэрчилсэн жагсаалтаар дахин боловсруулж байгууллагын даргаар батлуулан ажиллаа. Мөн байгууллагын архивт хадгалагдаж байсан 2022 оны байнга хадгалах баримтын Төрийн архивт цаасаар буюу цахимаар хуваарийн дагуу хугацаанд шилжүүлсэн. Гурванбулаг сумын 2008-2023 оны 277 иргэний 2602 хуудас, 14 хадгаламжийн нэгж үүсгэн газар өмчлөлийн нэгж талбарын хувийн хэргийг байгууллагын архивт татан төвлөрүүлж, цахимаар /сканердуулан/ болон цаасаар хүлээн авсан. | 100 |

**ХОЁР. ТӨРИЙН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЧАНАР, ХҮРТЭЭМЖИЙГ САЙЖРУУЛАХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ**

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.2 Газрын кадастрыг эрхлэх, төрөөс үзүүлж буй үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх** | | | | | | | |
| **2.2.1** | **Газрын кадастрын мэдээллийн сангийн нэгдсэн системээс авах үйлчилгээг иргэдэд хүртээмжтэй хүргэх** | **Урсгал зардал, үйл ажиллагаа** | **Хэрэглэгчийн тоо** | **Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 110 дугаар тогтоолоор Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн цахим системийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлсэн** | **www.egazar.gov.mn-ээс үйлчилгээ авсан хэрэглэгчийн хандалтыг 60 хувиар нэмэгдүүлсэн байна.** | | |
| 2.2.1.1 | Газрын кадастрын цахим системд зөрүүтэй бүртгэгдсэн өргөдөл, шийдвэр, гэрээ, иргэн, хуулийн этгээдийн мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулах. | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн системд засварласан нэгж талбарын тоо | Засвар, хяналтын модуль хэрэглээнд нэвтэрсэн. | **Эхний хагас жилд:** Засвар, хяналтын модулийг хэрэглээнд нэвтрүүлсэнтэй холбогдуулан Газрын кадастрын цахим системд зөрүүтэй бүртгэгдсэн мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулж мэдээллийн сангийн үнэн зөв байдал хангагдсан байна. | Сумдын газрын даамлуудын явуулсан зөрүүтэй мэдээллийн дагуу ерөнхий газарт явуулж засварлуулдаг байсан бол Засвар хяналтын модул ашиглалтанд орж Шийдвэртэй холбогдсон өргөдөл засварлах 447, гэрээний эхлэх, дуусах хугацаа, гэрээний зөвшөөрсөн, хүссэн хугацаа 49, иргэн, хуулийн этгээдийн засвар 41, бусад засвар 114 Нийт 651 засварыг хийж зөрүүтэй мэдээллийг шинэчилсэн. | 100 |
| 2.2.1.2 | Газар эзэмших, ашиглах болон түүнтэй холбогдон бусад хүсэлтийг цахим системээр хүлээн авч, шийдвэрлүүлэх, | Үйл ажиллагаа | Иргэн, хуулийн этгээдээс гаргасан хүсэлтийн тоо | Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (egazar.gov.mn)-ээр хүсэлт хүлээн авах | **Эхний хагас жилд:** Газар эзэмших, ашиглах болон түүнтэй холбогдон бусад хүсэлтийг цахим системээр хүлээн авч, | Газрын удирдлагын нэгдсэн цахим систем (egazar.gov.mn)-ээр дамжуулан Баянхонгор сум 319, Баянцагаан сум 4, Баян-Өндөр сум 6, Баян-Овоо сум 5, Баацагаан сум 3, Бууцагаан сум 2, Хүрээмарал сум 4, Жаргалант сум 6, Бөмбөгөр сум 19, Богд сум 6, Жинст сум | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | баталгаажуулах ажлыг зохион байгуулах | | | боломжтой болсон. | шийдвэрлүүлэн баталгаажуулсан байна. | 4, Баянлиг сум 7, Баянговь сум 24, Галуут сум 5, Баянбулаг сум 4, Эрдэнэцогт сум 5, Өлзийт сум 30, Шинэжинст сум 34, Гурванбулаг сум 11 нийт 498 цахим хүсэлт хүлээн авч шийдвэрлэсэн байна. | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.3. Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (shilenkhyanalt.gov.mn)-ийг хөтлөх** | | | | | | | |
| **2.3.1** | **Хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (shilenkhyanalt.gov.mn)-ийг хөтлөх;** | **-** | **Системд бүртгэсэн хяналт шалгалтын мэдээний хэрэгжилт** | **Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системд 2024 онд газрын харилцааны салбарын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын мэдээллийг оруулсан.** | **Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системийг хөтөлж, салбарын хэмжээнд хийгдсэн хяналт шалгалтын тайлан, мэдээг системээс гаргах боломжийг бүрдүүлнэ.** | | |
| 2.3.1.1 | Төрийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д орон нутгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн хяналтын чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын объектыг угсрах | - | Системд угсрагдаж баталгаажсан объектын тоо-15 | Хяналт, удирдлагын нэгдсэн цахим системд 2024 онд газрын харилцааны салбарын төлөвлөгөөт хяналт шалгалтад хамрагдах 15 объектыг угсарч, Ерөнхий газрын даргаар батлуулсан. | Орон нутгийн хэмжээнд газар, геодези, зураг зүйн чиглэлээр их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн объектыг төрийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим (Шилэн хяналт)-д угсарч Салбарын Улсын ерөнхий байцаагчаар батлуулсан байна. | Төрийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д их, дунд эрсдэлтэй үнэлэгдсэн төлөвлөгөөт хяналт шалгалтын 15 объектыг угсарч оруулсан. | 100 |
| 2.3.1.2 | Шилэн хяналт системд угсрагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтын объектын удирдамжийг угсрах | - | Системд угсрагдаж баталгаажсан удирдамжийн тоо-15 | Төлөвлөгөөт хяналт шалгалтын 15 объектын удирдамжийг угсарч, Ерөнхий | Шилэн хяналт системд угсрагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтын объектын удирдамжийг төрийн хяналт, удирдлагын нэгдсэн цахим (Шилэн хяналт)-д | Шилэн хяналтын системд угсрагдсан төлөвлөгөөт хяналт шалгалтын 15 объектын удирдамжийг угсарч оруулж, ГЗБГЗЗЕГ-ын даргаар баталгаажуулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | газрын даргаар батлуулсан. | угсарч Салбарын Улсын ерөнхий байцаагчаар батлуулсан байна. | | |
| 2.3.1.3 | Орон нутгийн хэмжээнд төлөвлөгөөт шалгалтад хамрагдах объектод хийгдсэн хяналт шалгалтын үр дүнг хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д бүртгэх | - | Системд баталгаажиж бүртгэгдэх хяналт шалгалтын тоо-15 | Төлөвлөгөөт шалгалтад 11 объектод хийгдсэн хяналт шалгалтын ажлын үр дүнг хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д бүртгэж баталгаажуулсан. | Төлөвлөгөөт шалгалтад хамрагдах объектод хийгдсэн хяналт шалгалтын үр дүнг хяналт шалгалтын удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д бүртгэж Улсын ерөнхий байцаагчаар батлуулсан байна. | Төлөвлөгөөт шалгалтад хамрагдсан 7 объект, төлөвлөгөөт бус шалгалтад хамрагдсан 2 объектод хийгдсэн хяналт шалгалтын үр дүнг хяналт, удирдлагын нэгдсэн цахим систем (Шилэн хяналт)-д бүртгэж оруулсан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.5. Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах** | | | | | | | |
| **2.5.1** | **Геодезийн хэмжих хэрэгслийг шалгах, баталгаажуулах** | **Үйл ажиллагаа** | **Улсын хэмжээнд ашиглаж буй бүх төрлийн геодезийн хэмжих хэрэгсэл** | **2024 онд геодезийн 2130 хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулсан.** | **Жил бүр геодезийн 2100-аас доошгүй тооны хэмжих хэрэгслийг олон улсын түвшинд нийцүүлэн, дэвшилтэт техник, технологи ашиглан шалгаж, баталгаажуулсан байна.** | | |
| 2.5.1.1 | Аймгуудын ГХБХБГ-т хэрэглэгдэж буй геодезийн хэмжих хэрэгслийг шалгаж, баталгаажуулах | Үйл ажиллагаа | 40 багажны шалгалт, баталгаажуулалт хийж мэдээллийн сан хөтлөх /Аймгууд электрон тахеометр, нивелирээ акталсан учир өмнөх оны хэмжээнээс тоо буурсан./ | 2024 онд 21 аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газарт хэрэглэж байгаа нийт 59 хэмжих хэрэгсэлд шалгалт, тохируулга хийж баталгаажуулсан. | **Эхний хагас жилд:**<br><br>Аймгийн ГХБХБГазарт хэрэглэгдэж байгаа геодезийн хэмжлийн 15 хэмжих хэрэгсэлд шалгалт, баталгаажуулалт хийж, гэрчилгээ олгон бүртгэлийг мэдээллийн санд оруулсан байна. | ГХБХБГазарт хэрэглэгдэж байгаа геодезийн хэмжлийн багажуудаа 2025 оны 06 сарын 02-ний өдөр баталгаажуулж ажиллалаа. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **2.6.1** | **1:1000-ны масштабтай тоон дэвсгэр зургийг шинээр гүйцэтгэх** | **Үйл ажиллагаа** | **:1000-ны масштабтай тоон дэвсгэр зураг** | **Нийслэл, Өмнөговь аймгийн төв, 4 сумын төвийг** | **ITRF2020 тогтолцоонд 21 аймгийн 330 сум, 45 суурин, нийслэлийн нутаг дэвсгэрт 1:1000 масштабтай тоон байр зүйн зургийг шинээр гүйцэтгэсэн байна.** | | |
| 2.6.1.1 | 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн санг шинэчлэх | Үйл ажиллагаа | 21 аймаг, нийслэл | 2024 онд геопортал цахим системийн байр зүйн зургийн дэд сан, дэд бүтцийн дэд санг 26 мэдээллээр шинэчилсэн. | 21 аймаг, нийслэлийн 1:1000-ны масштабтай байр зүйн тоон зураг, инженерийн дэд бүтцийн мэдээллийн сангийн шинэчлэлтэд хяналт тавьж баталгаажуулсан байна. | Urban цахим мэдээллийн санд 14 барилга, дулааны шугам 945.067м, дулааны худаг 31ш, ариутгах татуургын шугам 677.587м, холбооны шугам 86м, ариутгах татуургын худаг 35, цахилгааны шугам 229.467м, цахилгааны худаг 18ш, 0.4квт-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам 187.196м, бохир ус цэвэрлэх 1 байгууламж болон 3 тэг тэнхлэгийн мэдээллүүдийг бүрэн оруууллаа | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.8. Газрын нэгдмэл санг эрхлэх, ГНСангийн цахим системийг хөгжүүлэх** | | | | | | | |
| **2.8.1** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн удирдлагын системийн үйл ажиллагааг боловсронгуй болгох, хөгжүүлэлтийн ажлыг хийх, хэрэглээнд нэвтрүүлэх** | **Үйл ажиллагаа, Урсгал төсөв** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийг хөгжүүлсэн нэмэлт өөрчлөлтүүд** | **Газрын нэгдмэл сангийн удирдлагын нэгдсэн системийг улсын хэмжээнд нэвтрүүлсэн.** | **Газрын нэгдмэл сангийн нэгдсэн системийн үйл ажиллагааны хөгжүүлэлтийн ажлууд хийгдэж боловсронгуй болсон байна.** | | |
| 2.8.1.1 | МУЗГ-ын тогтоолын хавсралтаар улсын хэмжээнд 2025 онд гэр бүлийн хэрэгцээнд иргэнд эзэмшүүлэхээр | Үйл ажиллагаа | 2025 онд гэр бүлийн хэрэгцээнд иргэнд эзэмшүүлэхээр | 2024 онд хүсэлтийг газрын удирдлагын | **Эхний хагас жилд:** Гэр бүлийн хэрэгцээнд иргэнд эзэмшүүлэхээр батлагдсан жагсаалтын | Засгийн газрын тогтоолоор 2025 онд гэр бүлийн хэрэгцээнд иргэнд эзэмшүүлэхээр батлагдсан жагсаалтыг хэрэгжүүлж ажиллахдаа газрын удирдлагын нэгдсэн цахим системээр | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | батлагдсан жагсаалтын дагуу хүсэлтийг газрын удирдлагын нэгдсэн цахим систем (egazar.gov.mn)-ээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлүүлэх, баталгаажуулах ажлыг зохион байгуулах | | батлагдсан жагсаалтад хамаарагдах тоо | нэгдсэн цахим систем (egazar.gov.mn)-ээр дамжуулан хүлээн авсан | дагуу хүсэлтийг газрын удирдлагын нэгдсэн цахим систем (egazar.gov.mn)-ээр дамжуулан хүлээн авч, шийдвэрлүүлэн, баталгаажуулсан байна. | дамжуулан олголт хийх талаарх зөвлөмжийг Газрын даамлуудад 2025 оны 03 дугаар сард болсон танхимийн сургалтын үеэр өгсөн. Тайлант онд Хүрээмарал сумд иргэнд үнэ төлбөргүйгээр эзэмшүүлэхээр төлөвлөсөн 8 нэгж талбар Засгийн газрын 120 дугаар тогтоолоор батлагдсан. Дээрх газруудыг цахимаар олгохоор төлөвлөсөн бөгөөд Улсын хэмжээнд зохион байгуулах цахим хүсэлтийн 2 дугаар ээлжинд иргэдээс хүсэлт авахаар болсон. | |
| 2.8.1.3 | Эрх бүхий этгээдийн шийдвэрүүдэд цаасан эх хувийг нөхөн бүрдүүлж, хавсаргах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Эрх бүхий этгээдийн шийдвэрийн тоо | Системийн хөгжүүлэлт хийгдэж, шийдвэрийн бүртгэлд эх хувийг хавсаргах боломжийг бүрдүүлсэн. | **Эхний хагас жилд:** Эрх бүхий этгээдийн шийдвэрүүдэд цаасан эх хувийг нөхөн бүрдүүлж, хавсаргасан байна. | Аймгийн Засаг даргын захирамжийг мэдээллийн сангийн шийдвэрийн бүртгэлийн хавсралт хэсэгт оруулах ажлыг өдөр тутамдаа хийж гүйцэтгэж байна. Нийт 670 нэгж талбарын 730 өргөдлийн цахим архивыг засварлаж оруулсан. | 100 |
| 2.8.1.4 | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгуулах, Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажсан нэгж талбарын тоо | Газрын кадастрын мэдээллийн систем | **Эхний хагас жилд:** Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүй зөрчилтэй нэгж талбарын зөрчлийг арилгуулах, Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулсан байна. | Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдсэн мэдээллийг үнэн зөв болгох зөрчлийг арилгах ажлын хүрээнд Баянхонгор сум нэгж талбарын талбайн хэмжээ залруулсан захирамжтай сүүлийн өмчлөгчөөр бүртгэгдсэн байсан нэгж талбаруудыг анхны захирамжтай холбож гэр бүлийн нэг гишүүнд шилжүүлсэн, худалдсан, талбайн хэмжээ өөрчилсөн зэрэг 466 өргөдлийн нөхөн бүртгэл хийсэн.<br>Газрын кадастрын мэдээллийн санд бүртгэгдээгүйнэгж талбарыг, Газрын кадастрын мэдээллийн системд баталгаажуулах ажлын хүрээнд Баацагаан сум 1, Баянбулаг сум 1, Баянговь сум 2, Баян-овоо сум 5, Өлзийт сум 2, Бөмбөгөр сум 2, Бууцагаан сум 3, Жинст сум 2, Заг сум 5, Богд сум 1, Шинэжинст сум 4 нийт 32 нэгж талбарын нөхөн бүрдүүлэлт | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хийсэн. | |
| 2.8.1.5 | Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх ажлыг нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулсан гудамж, зам болон нэрэмжит болгосон талбайг мэдээллийн санд бүртгэх | Үйл ажиллагаа | Гудамж, замын тоо | Хаягийн мэдээллийн систем | **Эхний хагас жилд:** Нэр, хаяг олгогдоогүй гудамж, зам, талбайд нэр өгөх, нэрэмжит болгох ажлыг нийслэлийн ерөнхий архитектортай хамтран нийслэлийн хэмжээнд зохион байгуулж, ИТХ-ын тогтоолоор баталгаажуулж, нэр олгогдсон, нэрэмжит болгосон талбай, гудамж, замыг хаягийн мэдээллийн санд бүртгэсэн байна. | ГЗБГЗЗЕГ-н 2024.06.27-ны өдрийн 2/1655 дугаар албан бичгээр шинэ хаягжуулалт хийхийг түр зогсоох тухай чиглэл ирүүлсэн. ГЗБГЗЗЕГ-аас 2025 оны 03 сарын 12-ны өдөр “Хаягжуулалтын мэдээллийн сангийн шинэчлэлт”-ээр цахим сургалтыг зохион байгуулсан. Тус сургалтанд сумдын даамлуудын хамт хамрагдсан. Хаягийн мэдээллийн шинэ системийг улсын хэмжээнд хэрэглээнд нэвтрүүлэхтэй холбоотой 2024 оны 11 дүгээр сарын 29-ний едрийн 2/3308 дугаар албан бичгээр хүргүүлсэн “Хаягийн мэдээллийн системд оруулах өгөгдөл, мэдээг зураглах" аргачлалын дагуу гудамж, зам, орц, гарцыг зураглаж, өгөгдөл мэдээллийг боловсруулах ажлын бэлтгэлийг хангаж ажиллаж байна. | 100 |
| **2.8.2** | **Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, мэргэжил арга зүйн зөвлөгөө өгөх, хяналт тавих** | **Үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн үйл ажиллагаа** | **Газрын нэгдмэл сангийн мэдээллийн санг нэвтрүүлсэн.** | **Газрын нэгдмэл сангийн өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, мэргэжил арга зүйгээр хангаж ажилласан байна.** | | |
| 2.8.2.1 | Газрын нэгдмэл сангийн цахим системийн өгөгдөл, мэдээлэлд хяналт хийж, алдаатай, зөрүүтэй оруулсан мэдээллийг засварлах ажлыг зохион байгуулах | Үйл ажиллагаа | Газрын нэгдмэл сангийн цахим систем | Газрын нэгдмэл сангийн цахим систем | **Эхний хагас жилд:** Газрын нэгдмэл сангийн цахим системийн мэдээлэл засварлагдсан байна. | Газрын удирдлагын нэгдсэн системд Засвар хяналтын модул ашиглалтанд орж шийдвэртэй холбогдсон өргөдөл засварлах 447, гэрээний эхлэх, дуусах хугацаа, гэрээний зөвшөөрсөн, хүссэн хугацаа 49, иргэн, хуулийн этгээдийн засвар 41, бусад засвар- 114 нийт 651 засварыг хийж мэдээллийн зөрүүг арилгасан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.10.1.1 | Орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем /Геопортал/-ийн дэд санг стандартын дагуу бүрдүүлэх | Үйл ажиллагаа | Дэд сан бүрээр бүрдүүлсэн өгөгдлийн тоо | 2024 онд геопорталд дэд сан бүрээр өгөгдөл бүрдүүлсэн. | Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрдүүлсэн байрлалд суурилсан мэдээллийг орон зайн өгөгдлийн дэд бүтцийн систем / геопортал/-д 18 дэд сангийн стандартын дагуу баяжуулж, бүрдүүлсэн байна. | Urban цахим мэдээллийн санд 14 барилга, дулааны шугам 945.067м, дулааны худаг 31ш, ариутгах татуургын шугам 677.587м, холбооны шугам 86м, ариутгах татуургын худаг 35, цахилгааны шугам 229.467м, цахилгааны худаг 18ш, 0.4квт-ийн цахилгаан дамжуулах агаарын шугам 187.196м, бохир ус цэвэрлэх 1 байгууламж болон 3 тэг тэнхлэгийн мэдээллүүдийг бүрэн орууллаа. | 100 |
| 2.10.1.21 | Киоски төхөөрөмжийг хүртээмжийг нэмэгдүүлэх ажлыг зохион байгуулж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийтэд нэг цэгээс түргэн шуурхай хүргэх боломжийг бүрдүүлэх | Орон нутгийн төсөв | Шинээр нэвтрүүлсэн төхөөрөмжийн тоо | Аймийн хэмжээнд нийт 1 төхөөрөмжийг нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Киоски төхөөрөмжийг хүртээмж нэмэгдэж газартай холбоотой үйлчилгээг иргэд олон нийт нэг цэгээс түргэн шуурхай авах боломж бүрдсэн байна. | Сумдын Иргэдийн хурлын дарга, Засаг дарга нарт Газрын харилцааны бүтээгдэхүүн, үйлчилгээг иргэн, хуулийн этгээдэд хүргэх бүтээгдэхүүн үйлчилгээний нэр төрөл, чанарыг сайжруулах, тоо, хүртээмжийг нэмэгдүүлэх egazar.gov.mn цахим сайтаар үйлчилгээ авах нөхцөл боломжоор хангах зорилгоор киоск төхөөрөмж худалдан авч үйлчилгээнд нэвтрүүлэхийг зөвлөсөн албан бичгийг 2025.06.02-ны өдрийн 317 дугаар албан бичгээр хүргүүлсэн. | 100 |
| 2.10.1.22 | Тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Агентлаг 21 аймгийн ГХБХБГ-ын VPN тусгаарласан сүлжээний хэвийн үйл ажиллагаа | 21 аймаг тоон мэдээлэл дамжуулах байнгын холболтод холбогдсон. | **Эхний хагас жилд:** Салбарын тоон мэдээлэл дамжуулах байнгын холболт, интернэтийн сүлжээ, түүний аюулгүй хэвийн ажиллагааг хангаж ажилласан байна. | Интернэтийн сүлжээ, түүний аюулгүй, хэвийн ажиллагааг ханган ажилласан. | 100 |
| 2.10.1.23 | Байгууллагын цахим хуудасны хөгжүүлэлтийг хийх, хэвийн үйл ажиллагааг хангах, мэдээлэл оруулах | Үйл ажиллагаа | Байгууллагын цахим хуудсын нэмэлт хөгжүүлэлт, оруулсан мэдээллийн тоо | Байгууллагын цахим хуудсыг 2024 онд шинэчлэн хэрэглээнд нэвтрүүлсэн. | **Эхний хагас жилд:** Байгууллагын цахим хуудсыг шаардлагатай хөгжүүлэлтийг тухай бүр нь хийж, хэвийн үйл | Газрын харилцааны салбар 2025 оныг “Иргэдийн итгэлийг хүлээсэн төрийн үйлчилгээний жил” болгож зарласантай холбогдуулан Баянхонгор аймгийн Газрын харилцаа, барилга, хот | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | ажлыг хариуцсан албан хаагчтай хамтран гүйцэтгэх | | | | ажиллагааг хангасан байна. Байгууллагын цахим хуудсанд мэдээлэл оруулах ажлыг хариуцсан албан хаагчтай хамтран гүйцэтгэсэн байна. | байгуулалтын газар Газрын харилцааны ажилтны өдрийг салбарын хэмжээнд зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөө гаргаж түүний дагуу Баацагаан сумандо нээлттэй хаалганы өдөрлөгийг зохион байгуулсан. Нээлттэй хаалганы өдрөөр 7 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг шинэчлэж, 6 иргэний газар эзэмших эрхийн гэрчилгээг шилжүүлж, 22 иргэний гэрээ, гэрчилгээг шинэчлэж, 17 иргэний нэгж талбарт мэргэжлийн байгууллагаар хэмжилт хийлгэж, 18 иргэнд газар эзэмших шийдвэр гаргаж, 2 иргэний газрыг 2026 оны ГЗБТЖТөлөвлөгөөнд тусгаж, 68 иргэнд зөвлөгөө, мэдээлэл өгсөн. Тус нээлттэй хаалганы өдрийн мэдээллийг Баацагаан сумын нэгдсэн группд байршуулсан. | |
| 2.10.1.25 | Байгууллагын албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй программ хангамжийн хэвийн тасралтгүй, найдвартай ажиллагааг хангах | Үйл ажиллагаа | Програм хангамжийн хэвийн, тасралтгүй найдвартай ажиллагаа | 2024 онд байгууллагын албан хаагчдад давхардсан тоогоор 80 удаа програм хангамжийн хэвийн тасралтгүй найдвэртай ажиллагааг хангах үйлчилгээ үзүүлсэн. | **Эхний хагас жилд:** Байгууллагын албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй програм хангамжийн хэвийн тасралтгүй найдвартай ажиллагааг хангаж ажилласан байна. | Албан хаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд хэрэглэгдэж буй 11 принтерийг тэглүүлсэн, программ хангамжийн хэвийн тасралтгүй ажиллагааг хангаж ажиллалаа. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 2.11. Архивын цахим системээр үйлчилгээ үзүүлэх** | | | | | | | |
| **2.11.2** | **Төрийн архивын түүхийн үнэт баримтыг цахим хэлбэрт шилжүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх** | **Үйл ажиллагаа** | **Цахим системд холбосон, бар коджуулсан баримт** | **-** | **386 хадгаламжийн нэгж цахим системд холбон, 16315 хадгаламжийн нэгжийн баримтыг бар коджуулна.** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 2.11.2.1 | Архивын баримтыг цахимжуулах, цахим мэдээллийн сан үүсгэх | Үйл ажиллагаа | 2017, 2022 онуудын 35 хадгаламжийн нэгжийн 3031 хуудас баримтыг цахимжуулна | 2024 оны байдлаар 2021 оны 84 хн-ийн 1619 хуудас, 2008 оны 30 хн-ийн 1400 хуудас, 2009 оны 46 хн-ийн 1121 хуудас, 2010 оны 36 хн-ийн 936 хуудас, 2011 оны 36 хн-ийн 546 хуудас, 2012 оны 33 хн-ийн 639 хуудас, 2013 оны 32 хн-ийн 675 хуудас, 2014 оны 38 хн-ийн 676 хуудас, 2018 оны 76 хн-ийн 1269 хуудас нийт 9 оны 417 хн-ийн 8881 хуудас баримт цахимжсан. | **Эхний хагас жилд:** 2017, оны 55 хадгаламжийн нэгжийн 1031 хуудас баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын САХ-тэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна.<br>**Жилийн эцэст:** 2022 оны 80 хадгаламжийн нэгжийн 2000 хуудас баримтыг цахимжуулан Архивын цахим системд холбон, байнгын үйл ажиллагааг хангахад ГЗБГЗЗЕГ-ын САХ-тэй хамтран ажиллаж холбогдох зааварчилгаа авсан байна. | Байгууллагын архивт хадгалагдаж байсан 2022 оны байнга хадгалах баримтын аймгийн Төрийн архивын тасагт хуваарийн дагуу шилжүүлэн ажилласан. 2022 оны 78 хадгаламжийн нэгжийн 1749 хуудас, заалтын тоо 400, хүний нэр 879, байгууллагын нэр 172, газар зүйн нэр 60 гэсэн өгөгдлөөр Төрийн архивын cams.e-archives.gov.mn системд холбон цахимжуулсан. | 100 |
| 2.11.2.3 | Архивын баримтаар байгууллага, иргэдэд үйлчилгээ үзүүлэх, лавлагаа мэдээлэл олгох | Үйл ажиллагаа | Цаасан болон цахим баримтын үйлчилгээ | 2024 онд 42 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид 42 баримтын 1174 хуудас баримтаар үйлчилгээ үзүүлсэн. | Цаасан болон цахим баримтаар үйлчилгээ үзүүлсэн байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар 11 иргэн, байгууллага, аж ахуйн нэгжид 203 хуудас архивын баримтыг хуулбарлаж хуулбар үнэн тэмдэг дарж холбогдох нэгжийн даргаар гарын үсэг зурж баталгаажуулж, бүртгэлийн хөтөлсөн. | 100 |
| **2.11.3** | **Түүхийн үнэт баримтыг архивын хосгүй үнэт зүйлд бүртгүүлэх** | **Бэлтгэл ажил** | **1963-1990 онд агаараас авсан 1200 банк бүхий 354511 ширхэг гэрэл зургийн хальс төрийн архивт хадгалагдаж байна.** | **Төрийн архивт хадгалагдаж байна 1963-1990 онд агаараас авсан 354511 ширхэг гэрэл зургийн хальсыг цахимжуулж,** | **Хөрөнгө оруулалт Төсөл, хөтөлбөр** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | **хосгүй үнэт баримтад бүртгүүлэх** | | | |
| 2.11.3.5 | Аймгуудын ГХБХБГ-ын архивт нэгж талбарын хувийн хэргийг сумдаас татан төвлөрүүлэх | Үйл ажиллагаа | Нэгж талбарын хувийн хэрэг | ГЗБГЗЗГ-аас зохион байгуулсан сургалтанд хамрагдан зааварчилгааны дагуу 6 сумын 1707 иргэний 22424 хуудас нэгж талбарын хувийн хэргийг 108 хадгаламжийн нэгж болгон байгууллагын архиви хүлээн авч санд шилжүүлж, баримтыг цэгцэлсэн. | **Эхний хагас жилд:** 2 сумын 800 хувийн хэргийн бүрдлийг шалган акт үйлдэн хүлээн авч, мэдээг ГЗБГЗЗГ-т хүргүүлсэн байна. | 2025 оны эхний хагас жилийн байдлаар Гурванбулаг сумын газар өмчлөлийн нэгж талбарын хувийн хэргийг байгууллагын архивт татан төвлөрүүлж ажиллалаа. Үүнд: 2008-2023 оны 277 иргэний өмчлөлийн нэгж талбарын 2602 хуудастай хувийн хэргийн баримтыг 14 хадгаламжийн нэгж болгон хүлээн авлаа. | 100 |

## ГУРАВ. ХУУЛИАР ТУСГАЙЛАН ОЛГОСОН ЧИГ ҮҮРГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ

| Д/д | Стратеги төлөвлөгөө болон үндэслэж байгаа бусад бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт /хүрээгүй бол тайлбар/ | Гүйцэтгэлийн хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **Стартегийн төлөвлөгөөний зорилго 3.1. Улсын хил шалгалтын ажлыг зохион байгуулах** | | | | | | | |
| 3.1.2. | Газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх | Улсын төсөв | Монгол улсын нутаг дэвсгэрийн хэмжээнд хамаарах 350 мянган газар зүйн нэр | 2019-2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 16 аймгийн 117 сум, нийслэлийн 5 дүүргийн газар зүйн нэрийн тодруулалт, мэдээллийн сан бүрдүүлэх ажил хийгдсэн. | Газар зүйн нэрийг тодруулан тогтоож Улсын Их Хурлаар батлуулж, хаягжуулалтад ашигласан байна. | | |
| 3.1.2.1 | Газар зүйн нэрийн мэдээллийн сан хөтлөх | Үйл ажиллагаа | Газар зүйн нэрийн тодруулалт хийгдсэн 7 сум | 2024 онд 0 сум, газар зүйн нэрийн тодруулалтын ажил хийсэн, мэдээллийн сан бүрдүүлэх ажлыг гүйцэтгэсэн. | Аймаг нийслэл, сум дүүргийн газар зүйн нэрийн мэдээллийн сан иргүүлсэн тухай бүрд шинэчилнэ. | Баян-Өндөр, Шинэжинст сумдын газар зүйн нэрийн тодруулалтыг хийж дууссан бөгөөд Баян-Өндөр сумын ИТХурлаар 3 сарын 26-нд ажлын үр дүнг танилцуулж ажилласан байна. | 100 |
| 3.1.2.2 | Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлыг зохион байгуулах | Орон нутгийн төсөв | Газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлын төсөв батлагдсан сумын тоо | 2024 онд орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2 сумын нутаг дэвсгэрт хамаарах газар зүйн нэрийн тодруулалтыг хийсэн. | **Эхний хагас жилд:** Төсөвт батлагдсан сумын газар зүйн нэрийн тодруулалт хийх ажлын даалгаврыг хамтран боловсруулж батлуулан ажлыг эхлүүлнэ. | Тайлант онд Баянцагаан, Бууцагаан Жинст, Баянговь, Баянбулаг, Баян-Овоо зэрэг 6 сумын Газар зүйн нэрийн тодруулалт хийж мэдээллийн сан байгуулах ажлын даалгавар батлуулж, Жинст, Баянговь, Бууцагаан, Баянбулаг, Баян-Овоо, Баянцагаан сумдын газар зүйн нэрийн тодруулалт хийж, мэдээллийн сан бүрдүүлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүд шалгарч гэрээгээ байгуулсан. | 100 |
| 3.1.2.4 | Газар зүйн нэрийн зөвлөлийн үйл ажиллагааг зохион байгуулах | Урсгал төсөв | 1 төлөвлөгөө, Зөвлөлийн 2 удаагийн хурал | Газар зүйн нэрийн зөвлөл байгуулсан. | **Эхний хагас жилд:** Газар зүйн нэрийн зөвлөлийн 2025 онд хэлэлцэх асуудлын төлөвлөгөөг боловсруулж батлуулан Газар зүйн | БаянӨндөр, Шинэжинст сумын тодруулалт хийгдсэн газар зүйн нээрийг 2025 оны 06 сарын 30-нд аймгийн Газар зүйн нэрийн дэд зөвлөлийг хуралдуулан танилцуулахаар тов зарлан бэлтгэл ажлыг хангаж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | нэрийн салбар зөвлөлийн 1 удаагийн хурлыг зохион байгуулна. Салбар зөвлөлийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж мэргэжил арга зүйн удирдлагаар хангана. | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.2. Бүсчилсэн хөгжлийн үзэл баримтлалд нийцүүлэн, тогтвортой газар ашиглалтад чиглэсэн нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөлтийг боловсруулж, хэрэгжүүлэх** | | | | | | | |
| **3.2.1** | **Газар зохион байгуулалт, төлөвлөлтийн арга зүйн баримт бичгийг боловсронгуй болгох** | **Урсгал зардал** | **Боловсруулсан аргачлал** | **Аймаг, сумын газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах аргачлал батлагдсан** | **“Нийслэл, сум, дүүргийн газар зохион байгуулалтын тухайн жилийн төлөвлөгөөний аргачлал”, “Газар ашиглалтын тохиромжтой байдал, хэрэгцээт байдлын үнэлгээний аргачлал”-ыг боловсруулж, батлуулсан байна.** | | |
| 3.2.1.6 | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, биелэлтийг 4 дүгээр улиралд багтаан тайлагнах | Үйл ажиллагаа | 21 аймаг | Сумын тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө хэрэгжилт болон газар олголтын байдалд хяналт шинжилгээ, үнэлгээ хийсэн. | **Эхний хагас жилд:** Тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт тавьж, гарсан зөрчлийг арилгаж тайлагнасан байна. | Сумдын 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг цахим системд орсон эсэхэд хяналт хийж 2025 оны 01 дүгээр сарын 15-ний өдрийн дотор ГЗБГЗЗЕГазарт дүгнэлт авахаар хүргүүлсэн. 2025 оны Газар зохион байгуулалтын төлөвлөгөөг Засгийн газраас 119, 120 дугаар тогтоолуудаар баталсан.<br><br>Дээрх тогтоолуудыг Газрын даргын 2025 оны 179, 180 дугаар албан бичгээр сумдад хүргүүлж хэрэгжилтийг хангаж ажиллах талаарх заавар чиглэл өгсөн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 2025 оны эхний хагас жилийн байдлаар цахим системээр хяналт хийхэд аймгийн хэмжээнд 6 сумд 17 нэгж талбарын 268.2 га газар төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу Газар зохион байгуулалт, хот төлөвлөлтийн цахим системээр дамжуулан холболт хийж эзэмшүүлсэн байна. | |
| 3.2.1.7 | Сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд санал авах, боловсруулах, дүгнэлт авах, батлуулах, батлагдсан төлөвлөгөөг ГЗБГЗЗЕГ-т ирүүлэх ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулж, холбогдох мэргэжилтнүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах. | Үйл ажиллагаа | 21 аймаг | МУ-ын ЗГ-ын 2024 оны 92 дугаар тогтоол | **Эхний хагас жилд:** Газар зохион байгуулалт хийх журмын хугацааг баримтлан сумын 2026 оны газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийг байгуулах, иргэд, олон нийтээс төлөвлөгөөнд санал авах ажлыг аймгийн хэмжээнд зохион байгуулах, холбогдох мэргэжилт-нүүдийг мэргэжил арга зүйгээр хангаж ажиллах. | Газар зохион байгуулалт хийх журмын дагуу эхний хагас жилд багтаан төлөвлөгөөг боловсруулах ажлын хэсгийн захирамжийг гаргах, иргэд олон нийтээс санал авах ажлыг зохион байгуулах чиглэлийг сумдад Газрын даргын 2025 оны 38 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Үүний дагуу эхний хагас жилийн байдлаар 2026 оны ГЗБТөлөвлөгөө боловсруулах ажлын хэсгийн захирамж Баянбулаг, Баян-Овоо, Богд, Галуут, Өлзийт, Эрдэнэцогт, Баян-Өндөр, Баянхонгор, Баянговь, Гурванбулаг, Бөмбөгөр, Хүрээмарал, Жинст, Заг, Баацагаан, сумууд гаргасан байна.<br><br>Байгууллагын фэйсбүүк хуудсаар ГЗБТухайн жилийн төлөвлөгөөнд санал авах зарыг оруулж олон нийтэд түгээсэн.<br><br>Мөн 2025 оны 03 дугаар сарын 10-13-ний хооронд Газрын даамлуудад зохион байгуулсан сургалтаар ГЗБайгуулалт хийх журамд заасан хугацааны дагуу тухайн жилийн төлөвлөгөөг боловсруулах ажлыг зохион байгуулах талаарх мэргэжил аргазүйн зөвлөгөө өгсөн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.2.1.3 | Орон нутгийн онцлогт нийцүүлэн Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмыг боловсруулан, аймгийн ИТХ-аар хэлэлцүүлэн батлуулах | Үйл ажиллагаа | 21 аймаг | - | **Эхний хагас жилд:** Бэлчээр ашиглах, хамгаалах нийтлэг журмын төслийг боловсруулж, хянуулан, санал авах ажлыг зохион байгуулсан байна. | Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн ерөнхий газар нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Дорнод Монголын хуурай хээрийн тогвортой ландшафт биологийн олон янз байдлын хамгаалал төсөлтэй хамтран “Бэлчээр ашиглах, хамгаалах, сайжруулах журам”-ын төслийг жишиг байдлаар боловсруулсан.Тус журмын төсөлд санал авахаар Байгаль орчин аялал жуулчлалын газар, Хүнс хөдөө аж ахуйн газар, Их богдын байгалийн цогцолборт газрын хамгаалалтын захиргаа, Ус цаг уур орчны шинэжилгээний газар, сумдын засаг дарга нараас санал авахаар газрын даргын 2025 оны 231 тоот албан бичиг явуулсан. Албан бичгийн дагуу ирүүлсэн саналыг нэгтгэх, дүн шинэжилгээ хийх ажил зохион байгуулж байна. | 70 |
| 3.2.1.8 | Сумдын газрын даамлыг мэргэжил, арга зүйн зөвлөгөө, мэдээллээр хангах, сургалт зохион байгуулах | Үйл ажиллагаа | 21 аймаг | - | Улиралд нэг удаа цахим болон танхимаар сургалт зохион байгуулсан байна. Сургалт зохион байгуулсан тайлан мэдээг тухай бүр тайлагнасан байна. | Байгууллагын албан хаагчид болон сумдын Газрын даамлуудад 2025 оны 03 дугаар сарын 11-ны өдөр Хаягийн мэдээллийн системийн шинэчлэгдсэн хувилбарын сургалт, Хууль эрхзүйн хэлтсийн мэргэжилтэн н.Лхамдулам Төрийн албан хаагчийн ёсзүйн тухай хууль сэдвээр сургалт явуулсан. Өвөрхангай аймагт зохион байгуулагдсан “Бүсчилсэн хөгжил-Төрийн албаны манлайлал” хангайн бүсийн зөвлөгөөнд байгууллагын төлөөлөл хамрагдаж Төрийн албан хаагчийн Ёсзүйн хууль тогтоомжийн талаар мэдээлэл авсан дээрх мэдээллийн байгууллагын албан хаагчдад өгсөн. Мөн 2025.04.24-ний өдөр Газар эзэмших ашиглах эрхийн гэрчилгээ олгох журмын сургалтыг цахимаар зохион байгуулсан. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.3. Геодези, зураг зүйн тухай хуулийг шинэчлэн батлуулах** | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **3.3.1** | **Геодези, зураг зүйн тухай хуулийн төслийг боловсруулж батлуулах,** | **Үйл ажиллагаа** | **Геодези, зураг зүйн хуулийн төслийн үзэл баримтлал** | **Геодези зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг шинэчлэн боловсруулсан.** | **Геодези, зураг зүйн тухай хуулийн үзэл баримтлалыг батлуулсан байна.** | | |
| 3.3.1.2 | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг олон нийтэд хэлэлцүүлэх | Үйл ажиллагаа | 1 хуулийн төсөл | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн үзэл баримтлалын төслийг 2023 онд олон нийтээр хэлэлцүүлсэн. | **Эхний хагас жилд:** Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хэлэлцүүлэг зохион байгуулах, сурталчлах, шаардлагатай мэдээ, мэдээллээр хангахад хамтран ажиллана. | Геодези, зураг зүйн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөлтэй танилцаж 2025 оны 313 тоотоор саналаа хүргүүлсэн. | 100 |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах** | | | | | | | |
| **3.7.1** | **Хяналт шалгалтын үйл ажиллагаа хэрэгжүүлэхэд шаардагдах баримт бичгийг шинэчлэн боловсруулах** | **Үйл ажиллагаа** | **Шинэчлэн батлагдсан эрсдэлийн шалгуур үзүүлэлт-1 Батлагдсан хяналтын хуудас-1** | **2024 онд Салбарын хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлтийг шинэчлэн боловсруулах журам", "Хяналт шалгалтын баримт бичгийг бүртгэх, дугаар олгох журмуудад нэмэлт өөрчлөлт оруулсан.** | **Салбарын хэмжээнд мөрдөгдөж буй хяналт шалгалтын объектыг эрсдэлийн ангилалд хамааруулах шалгуур үзүүлэлт, шалгалтад хамрагдах объектыг шалгах хяналтын хуудсыг шинэчлэн боловсруулж, хяналт шалгалтыг үр дүнтэй, ил тод, нээлттэй болгох, аливаа нөлөөллөөс ангид, адил тэгш, хараат бусаар хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлсэн байна.** | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 3.7.1.3 | Газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагч нарт зориулсан чадавхжуулах сургалтад хамрагдах | Үйл ажиллагаа | Батлагдсан төлөвлөгөөний дагуу зохион байгуулсан сургалтын тоо | Аймгийн Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын дарга, газар, геодези, зураг зүйн хяналтын улсын (ахлах) байцаагчдад 2024 онд нийт 5 удаагийн цахимаар болон танхимаар сургалт зохион байгуулсан. | Батлагдсан удирдамж, хөтөлбөрийн дагуу чадавхижуулах сургалтад идэвхи, санаачлагатай оролцсон байх. | ГЗБГЗЗЕГ-аас 2025 оны 01 дүгээр сарын 03, 02 дугаар сарын 12-ны өдөр зохион байгуулсан 2 удаагийн сургалтад батлагдсан хөтөлбөрийн дагуу цахимаар оролцсон. | 100 |
| 3.7.1.4 | Орон нутгийн хэмжээнд Газар, геодези, зураг зүйн хяналт шалгалтын чиглэлээр иргэд, олон нийтэд чиглэсэн рийл, постер, мэдээ мэдээлэл бэлтгэж олон нийтэд хүргэх | Үйл ажиллагаа | Батлагдсан төлөвлөгөөний дагуу авсан арга хэмжээний тоо | 2024 онд хяналт шалгалтын зөвлөмж, 45 минутын видео заавcovрыг бэлтгэж хүргүүлсэн. | Газрын харилцааны салбарт түгээмэл гарч байгаа зөрчлийг бууруулах зорилгоор иргэд, олон нийтэд урьдчилан сэргийлэх рийл, постер, мэдээ мэдээлэлийг хүргэсэн байна. | Хийгдээгүй байна. Төлөвлөсөн хугацаа болоогүй. | 100 |
| **3.7.4** | **Улсын тусгай хэрэгцээний газрын газар зохион байгуулалтыг эрхлэх** | **Үйл ажиллагаа** | **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авсан Улсын Их Хурлын тогтоол, Засгийн газрын тогтоол** | **Засгийн газрын тогтоол, тэмдэглэлээр өгөгдсөн үүрэг даалгавар, холбогдох байгууллагуудаас санал ирүүлсэн** | **Газрыг улсын тусгай хэрэгцээнд авах, гаргах асуудлын хэрэгцээ, шаардлагыг тодорхойлох, холбогдох судалгаа, дүгнэлтийг гаргаж, эрх бүхий байгууллагаар шийдвэрлүүлсэн байна.** | | |
| 3.7.4.8 | Хилийн боомтын бүсийн зориулалтаар улсын тусгай хэрэгцээнд авах газрын нөлөөлөлд өртөж буй нэгж талбарын | Үйл ажиллагаа | Баянхонгор<br>Увс<br>Дорнод<br>Хэнтий<br>Булган<br>Баян-Өлгий<br>Хөвсгөл<br>Сүхбаатар | Засгийн газрын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн тэмдэглэл | Эхний хагас жилд: Нөлөөлөлд өртөж буй нэгж талбарын судалгаа, газар ашиглалтын судалгааг нарийвчлан гаргах, иргэн, хуулийн этгээдэд мэдэгдэл | Хамааралгүй | үнэлэхгүй |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | судалгаа, газар ашиглалтын судалгааг нарийвчлан гаргах, сонсох ажиллагааг зохион байгуулах, мэдэгдэл хүргүүлэх, Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх ажлыг зохион байгуулах, тогтоолын эх хувийг ГЗБГЗЗЕГ-т хүргүүлэх | | Сэлэнгэ<br>Дорноговь<br>Завхан<br>Ховд<br>Говь-Алтай<br>Өмнөговь | | хүргүүлэх, сонсох ажиллагааг зохион байгуулах, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хэлэлцүүлэх | | |
| **Стратеги төлөвлөгөөний зорилго 3.7. Газрын харилцааны салбарын хяналт шалгалтын эрх зүйн орчныг сайжруулах, нэгдсэн удирдлагаар хангах** | | | | | | | |
| **3.7.5** | **Газрын зөрчил, маргаантай холбоотой асуудлыг шийдвэрлэх, холбогдох арга хэмжээг зохион байгуулах** | **Үйл ажиллагаа** | **Шийдвэрлэсэн албан бичиг, өргөдлийн тоо** | **2024 онд иргэний болон захиргааны шүүх, Авлигатай тэмцэх газар, эрх бүхий байгууллагаас ирүүлсэн 218 албан бичиг, иргэний 63 өргөдлийг шийдвэрлэсэн.** | **Шүүх, Авлигатай тэмцэх газар болон эрх бүхий байгууллагаас шинжээчээр томилсон тогтоол, захирамжийн хэрэгжилтийг хангах, дүгнэлт гаргах, нотлох баримтыг хүргүүлсэн байна.** | | |
